

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Газрын захирал: Д.Ганбилэг

Аудитын менежер: Х.Баярмаа

Ахлах аудитор: Ц.Гэрэл
Аудитор: П.Цэнгүүн
Д.Болормаа

Шинжээч: Б.Нямхүү

2011 оны 5 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.

www.mnao.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факс, mnao@mnao.mn имэйл хаягаар харилцана уу

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол улс

Товчилсон үгсийн жагсаалт.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3
Бүлэг 1: БСШУ-ны салбарт хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	5
• Зураг төсөвгүй барилга объект төлөвлөдөг явдал арилахгүй байна	5
• Хуульд заасан гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа хоёрыг адилтгаж ойлгосноос гэрээний заалт хэрэгжихгүй байна	8
• Өмнөх онуудын төлөвлөлтийн алдаа хөрөнгө оруулалтын цаашдын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна	10
Бүлэг 2: ЭМ-ийн салбарт хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	16
• Зураг төсөв бэлэн болох үед төсөвт өртөг нэмэгдэж байна	16
• Тендерийг хэт хугацаа алдаж зарласны улмаас гүйцэтгэгчтэй байгуулах гэрээ оройтож, бодит бус гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна	18
• Орон нутагт эрх шилжсэн ажлын чанар хангалтгүй, хяналт сулаас барилгын ажил сунжирч байна	20
Дүгнэлт:.....	22
БСШУЯ-ны санал	23
ЭМЯ-ны санал	27
ҮАГ-ын тайлбар	28
Зөвлөмж:	29
Хавсралт -1: БСШУ-ны салбарт улсын төсвөөс 2010 онд санхүүжүүлсэн барилга объектын судалгаа	30
Хавсралт -2: ЭМ-ийн салбарт улсын төсвөөс 2010 онд санхүүжүүлсэн барилга объект, их засварын ажлын судалгаа	42
Хавсралт -3: БСШУЯ-ны БЗА-ны инженерүүдийн явцын хяналтаар илэрсэн зөрчил	49
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БГД	Баянгол дүүрэг
БЗА	Барилга захиалагчийн алба
БЗД	Баянзүрх дүүрэг
БУА	Барилга угсралтын ажил
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол улс
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОУБ	Олон улсын байгууллага
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ХУД	Хан-Уул дүүрэг
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооноос ирүүлсэн санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

БСШУ-ны болон ЭМ-ийн салбарт 200 онд Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Энэ зорилтын хүрээнд дараахь чиглэлээр аудит хийв. Үүнд:

- 2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,
- Худалдан авалт, тендерийг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэн зөв гаргасан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад БСШУЯ, ЭМЯ болон тэдний харъяа зарим байгууллага, барилга объект хамрагдлаа.

Арга зүй, стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- МУ-ын 2010 оны төсвийн тухай хууль, төсвийн тодотголоор батлагдсан хөрөнгө оруулалтын судалгаа, материалыг гаргуулан харьцуулах
- Хөрөнгө оруулалтын зориулалт, чиглэл, тухайн салбарын дунд хугацааны бодлого төлөвлөлт болон ЗГ-ын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудтай уялдаж байгаа эсэхийг шалгах,
- Хөрөнгө оруулалт тухайн бүс нутгийн хүн амын байршил, шилжилт хөдөлгөөнтэй уялдсан эсэхэд дүгнэлт хийх,
- Барилга объектын хэрэгжилтийн явцтай түүвэрчлэн танилцах, явцын хяналтын баримт материалд дүн шинжилгээ хийх,
- Хэрэгжилт удаан барилга объектын талаар холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, шалтгааныг судлах, тайлбар тодруулга авах
- Хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн хэлбэлзлэл, түүний шалтгааныг судлах

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын гуравдугаар багийн аудитор, шинжээч нар хийж гүйцэтгэв.

- Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Зураг төсөвгүй барилга объект төлөвлөдөг явдал арилахгүй байна

- 1.1 “Зарлагын хязгаар батлах тухай” ЗГ-ын 2009 оны 220 дугаар тогтоолд БСШУ-ны салбарын 2010 оны хөрөнгийн зардлыг 50.0 тэрбум төгрөгөөр тогтоожээ.
- 1.2 Сангийн сайдад хүргүүлсэн “БСШУ-ны салбарын урсгал болон хөрөнгө оруулалтын 2010 оны төсвийн төсөл, 2011-2012 оны төсвийн төсөөлөл”-д 161.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий шилжих болон шинээр эхлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн онд 96.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийх, үүнээс 30.8 тэрбум төгрөгийг шилжих барилгад зарцуулах санал тусгасан байна.
- 1.3 ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн 2010 оны Төсвийн тухай хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын дээрх саналыг 61.9 тэрбум төгрөг болгон хянаж, УИХ Төсвийн тухай хуулиар 54.0 тэрбумаар, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 75.4 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.
- 1.4 Энэ нь БСШУЯ-ны боловсруулсан саналаас 21.9 хувиар буурсан бол өмнөх оноос 59.7 хувиар нэмэгджээ. 2010 оны төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын зориулалт дараахь байдалтай байна.

Хөрөнгө оруулалт	Дүн (сая төг)	Хувийн жин
Шилжих барилга	36246.2	48.0
Шинээр эхлэх барилга	19110.0	25.3
Их засвар	9928.7	13.2
Тоног төхөөрөмж	10193.3	13.5
Дүн	75478.2	100.0

- 1.5 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар БСШУС-ын багцад нийт 31.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 131 төсөл арга хэмжээнд 20.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2010 онд хийхээр нэмж баталсан байна.
- 1.6 Эдгээр төсөл арга хэмжээ нь тус яамны санал, дунд хугацааны төлөвлөгөөтэй хэрхэн нийцэж байгааг авч үзвэл:

Үзүүлэлт	ТАХ тоо	/Сая төгрөг/	
		Төсөвт өртөг	2010 онд баталсан санхүүжилт
БСШУЯ-ны саналд тусгагдсан боловч төсвийн тухай хуулиар хасагдаад тодотголоор эргэж нэмэгдсэн	19	12075.4	3481.8
БСШУЯ-ны саналд тусгагдаагүй бөгөөд тодотголоор нэмэгдсэн	112	19245.8	17478.8
Дүн	131	31321.2	20960.0

- 1.7 ЗГ-ын 2006 оны 192 дугаар тогтоолоор баталсан “МУ-ын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд хүүхдийн цэцэрлэгийг 8.0 мянган ороор, ЕБС-ийн хичээлийн байрыг 72.3 мянган суудлаар, ЕБС-ийн дотуур байрыг 5.2 мянган ороор нэмэгдүүлэх, ЗГ-ын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт баг

бүрт гэр цэцэрлэг байгуулах, ЕБС-ийн хичээлийн ээлжийн коэффициентийг бууруулж, сурагчдын дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлэхээр заасан байна.

- 1.8 БСШУЯ-ны 2009-2010 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэлд хичээлийн ээлжийн коэффициентийн улсын дундаж 1.3 байна.
- 1.9 Сургуулийн хүүхдийн тоог суудлын тоотой харьцуулсан судалгаагаар Баянхонгор аймагт 8, Хөвсгөл аймагт 7, Өвөрхангай аймагт 6, Завхан аймагт 5, Баян-Өлгий, Архангай аймагт 4, Увс, Өмнөговь аймагт 3, Ховд, Төв аймагт 2, Булган, Сэлэнгэ, Говь-Алтай, Сүхбаатар, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь аймагт тус бүр 1 сургуулийн хичээлийн ээлжийн коэффициент 2.0-оос дээш байна.
- 1.10 Мөн нийслэлийн БЗД-т 6, СХД-т 4, ЧД-т 3, БГД, ХУД, СБД, Налайх дүүрэгт тус бүр 1 сургуулийн хичээлийн ээлжийн коэффициент 2.0-оос дээш байгаагийн дотор Баянхонгор аймгийн Баян ойт сургууль 3.7, БЗД-ийн 79-р сургууль 3.3 байгаа нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт юм.
- 1.11 БСШУЯ шинээр барих, өргөтгөх барилга объектын талаарх салбарын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, УИХ-ын гишүүдийн саналыг үндэслэн хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулсан байна.
- 1.12 Дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан барилгын зураг төсвийг Сангийн сайдын төсвийн багцад батлагдсан ” БСШУ-ны салбарт зураг төсөв зохиох, ТЭЗҮ боловсруулах” төсөвт багтаан хийлгэсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгаж байна.
- 1.13 Гэвч зураг, төсөв нь бэлэн болоогүй зарим барилга объект төлөвлөгдөж байгаагаас хэрэгжилтийн шатанд элдэв хүндрэл бэрхшээл гарсаар байна.
- 1.14 2010 оны хөрөнгө оруулалтаар батлагдсан зарим барилга байгууламжийн хувьд барилга угсралтын ажлын явцад батлагдсан төсөвт өртгөөс 3.6 тэрбум төгрөгөөр анхны төсөвт өртөг нь нэмэгджээ. Тухайлбал,

- Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын 640 суудалтай сургуулийн барилгад 300 сая төгрөг батлагдаж, орон нутагт зураг төсөл хийлгэхэд төсөвт өртөг нь 1600.0 сая төгрөг болсон тул яаманд шилжиж, 2011 оны 1 дүгээр сард гэрээ хийгдсэн,
- Архангай аймгийн Өндөр-Улаан сумын цэцэрлэгийн барилгын төсөвт өртөг анх 446.0 сая төгрөгөөр батлагдсан ч орон нутагт эрх шилжсэний дараа төсөвт өртөг 653.0 сая төгрөг болж нэмэгдсэн байна. Гэвч 2011 онд үлдэгдэл төсөв нь УИХ-аар батлагдаагүйгээс барилга угсралтын ажил удаашрах хандлагатай болсон,
- Төв аймгийн ЗД-ын төсвийн багцад Баянчандмань сумын 640 хүүхдийн сургуулийн барилгад 500.0 сая, Баян Өнжүүл сумын 320 хүүхдийн сургуулийн барилгад 300.0 сая төгрөг тус тус батлагдсан,
- Аймгийн ЗД, Баянчандмань сумын сургуулийн барилгын гүйцэтгэгч “Тусгал төв” ХХК-тай 500.0 сая, Баян Өнжүүл сумын сургуулийн барилгын гүйцэтгэгч “Хангилцаг” ХХК-тай 295.0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажил эхэлсэн хойно төсвийн тодотголоор БСШУ-ны сайдын багц руу шилжүүлэн баталж, улмаар БСШУЯ-нд эрх шилжсэн,
- Баянчандмань сумын сургуулийн барилгын зураг төсвийг “Цэнхэр төхөм” ХХК зохиож, 2009 оны 6 дугаар сарын 9-ний өдөр улсын

экспертиз Н.Доржпалам магадлал хийснээр 1679.9 сая төгрөг, Баян Өнжүүл сумын сургуулийн барилгын зураг төсвийг “ТГТ” ХХК зохиож, 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр улсын экспертиз А.Эрдэнэчимэг магадлал хийснээр¹ 1280.3 сая төгрөг болсон байна,

1.15 Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар төсөл арга хэмжээг нэмж батлахдаа тэдгээрийн үргэлжлэх хугацаа, төсөвт өртгийг бодитой тогтоогүйгээс зарим ажил хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- Архангай аймгийн Батцэнгэл, Цэнхэр сумдын спорт заал, Хашаат сумын дотуур байрны барилгуудад төсвийн тодотголоор тус бүр 250 сая төгрөгийн төсөв баталж, 2010 онд хэрэгжүүлэхээр хуульд заасан боловч төсөвт өртөг нь хүрэлцээгүй тул 2011 онд дамжсан.*
- Төв аймгийн Бүрэн сумын цэцэрлэгт 150.0 сая, Батсүмбэр сумын Цогт-Өндөр багийн 25 хүүхдийн цэцэрлэгийн барилгад 30.0 сая, Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгад 300.0 сая, Төгрөг сумын сургуулийн 160 хүүхдийн суудалтай өргөтгөлд 50.0 сая, Дарви сумын цэцэрлэгийн барилгад 100.0 сая, Ховд аймгийн Жаргалант сумын сургуулийн барилгад 110.0 сая, Дарви сумын сургуулийн өргөтгөлд 300.0 сая, Увс аймгийн Улаангом сумын Эрдэм оргил, Шинэ ирээдүй сургуулийн хичээлийн байрны өргөтгөлд 230.0 сая төгрөг тус тус баталж 2010 онд хэрэгжүүлэхээр заасан ч төсөвт өртөг хүрэлцээгүй, үргэлжлэх хугацаа богино байснаас ажлын гүйцэтгэл 15-66 хувьтай байна.*

1.16 Захиалагч ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4²-д зааснаар нийт төсөвт өртгийн хэмжээнд тендер зарлан гэрээ байгуулах ёстой, Барилгын тухай хуулийн 16.8 -³ 16.9-д⁴ зааснаар шалгарсан гүйцэтгэгч уг барилгын ажлыг дуустал үргэлжлүүлэх ёстой.

1.17 Гэтэл Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар баталсан “Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журам”-ын 1.6⁵ -д тухайн жилд батлагдсан хөрөнгийн хэмжээнд багтаан гэрээ байгуулж байхаар журамласан нь дээрх хуулиудын заалттай зөрчилдөж ирсэн байна..

1.18 Иймээс зарим захиалагч он дамжин хэрэгжих БУА-д тухайн жилд батлагдсан төсөвт багтаан жил бүр тендер зарлаж, тус тусдаа гэрээ байгуулсан байна. Тухайлбал,

¹ Барилгын тухай хуулийн 13.2-т “Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ”

² Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно

³ “Сонгон шалгаруулалтад оролцож барилгын ажлын гүйцэтгэгчийн эрх авсан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барилга байгууламжийн үндсэн ажлыг бие даан гүйцэтгэнэ”,

⁴ Барилга байгууламжийн үндсэн ажилд суурь, хана, хучилт, шат, араг бүтээц, дээврийн ажил орно”

⁵ “салбарын яам, газар, аймаг, нийслэл нь төсвийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүр дээр батлагдсан хөрөнгийн хэмжээнд багтаан ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендер зарлаж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллах бөгөөд хөрөнгийг хэтрүүлэн зарцуулахыг хориглоно”

- Төв аймгийн Баянчандмань, Баян Өнжүүл сумдын сургуулийн барилгын гүйцэтгэгчидтэй Төв аймгийн Засаг дарга 2010 онд батлагдсан төсөвт багтаан 295.0-500.0 сая төгрөгийн гэрээ хийсэн,
- Хөвсгөл аймгийн Рашаант сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажил 2008 оноос эхэлсэн боловч дуусаагүй, 2010 онд батлагдсан 50.0 сая төгрөгөөр "Хөхтэнгэр хөвсгөл" ХХК-тай гадна, дотор засал, цахилгаан, хаалганы ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж, 2011 онд батлагдсан 131.0 сая төгрөгт багтсан гэрээг дахин хийх болсон,
- 2008 оноос хэрэгжиж байгаа Гандантэгчилэн хийдийн 1080 лам хурал хурах "Их цогчин дугана" -ын БУА-ын нийт төсөвт өртөг 2009-2010 оны төсвийн тухай хуулиудад 2500.0 сая төгрөгөөр тусгагдаж байсан бол 2011 оны хуульд 11700.0 сая төгрөг болж өссөн,
- Иймээс МУХС-гаас 2008 онд 500.0 сая, улсын төсвөөс 2009 онд 1000.0 сая, 2010 онд 1000.0 сая, 2011 онд 3100.0 сая, нийт 5600.0 сая төгрөг тус тус батлагдаад байна.
- 2008 онд Гандантэгчилэн хийдийн захиргаа, "Макс Өргөө" ХХК-тай хийсэн гэрээ ёсоор 295.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын газар шороо, суурийн ул бетоныг ажлын зургийн дагуу 10 см зузаантай байхыг 5 см зузаантай цутгасан, үлдсэн хөрөнгөөр газар чөлөөлөх, бэлтгэл ажил хийсэн бол 2009-2010 онд яамны тендерт шалгарсан "Си Эйч Си" ХХК-тай батлагдсан төсөвт багтаан жил бүр гэрээ хийсэн байна.

1.19 Харин Сангийн сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар дээрх журмыг шинэчилэн баталж он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний хувьд хуульд заасан төсөвт өртөгт багтаан гэрээ хийхийг тодорхой болгосон байна.

1.20 Түүнчлэн орон нутагт барилгын хүчин чадлыг нэмэгдүүлснээс хөрөнгө дутагдаж, хугацаа алдах явдал гарч байна. Тухайлбал,

- Архангай аймгийн Цэцэрлэг сумын 100 ортой цэцэрлэгийн БУА орон нутагт эрх шилжсэн бөгөөд анх 50 ортой, 262.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийг "Аяа" ХХК 2008 оноос барьж эхэлсэн боловч дараа нь хүчин чадлыг 100 ортой болгон нэмэгдүүлснээс суурь томсч төсөвт өртөг 428.0 сая төгрөг болсон, дахин зураг хийлгэх, дутуу хөрөнгийг батлуулахад цаг алдаж 3 жил сунжирсан байна.

Хуульд заасан гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа хоёрыг адилтгаж ойлгосноос гэрээний заалт хэрэгжихгүй байна

1.21 БСШУЯ тендерийн хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг өдөр тутмын сонин хэвлэлээр нийтэд зарлан, тайланг Сангийн яаманд хүргүүлж, хөрөнгө оруулалтын ажил тутамд ТНБД-ын тушаалаар үнэлгээний хороо байгуулж ажилласан байна.

1.22 Тус яамны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Сангийн яам хангалттай гэж үзэн 100 онооноос 60 оноо өгсөн байна.

- 1.23 Сангийн яамны худалдан авах ажиллагааны цахим хуудаст байршуулах босго үнэд хүрсэн 90 худалдан авах ажиллагааны 63 урилгыг байршуулж, түүнээс **6 тендерийн** үр дүнг мэдээлээгүй байна.
- 1.24 Тус салбарт 2010 онд 175 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтаар 61.3 тэрбум, 3 удаагийн хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар 0.6 тэрбум, 163 удаагийн харьцуулалтын аргаар 6.0 тэрбум, 1 удаагийн шууд гэрээгээр 0.1 тэрбум, нийт 342 удаагийн 67.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийжээ.
- 1.25 Нийт худалдан авалтын 90.3 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 8.8 хувийг харьцуулалтын аргаар, 0.8 хувийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар, 0.1 хувийг шууд гэрээгээр хэрэгжүүлсэн байна.
- 1.26 Тус яам хэт бага үнийн саналаар тендерт ялж, явцын дунд үнийн зөрүү нэхэмжлэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулахгүй саатуулдаг сөрөг явдлыг зогсоох зорилгоор тендерийн үнийн доод хязгаарыг хяналтын төсвөөс тооцон ТББ-т тусгах ажлыг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.
- *Баянхонгор аймгийн Бууцагаан сумын соёлын төвийн барилгад төсвийн тухай хуулиар 460.0 сая, үнэлгээний хорооны хуралд нарийн бичгийн даргын танилцуулснаар 505.0 сая, улсын экспертиз н.Цэрэнбалтав магадлал хийсэн 689.1 сая төгрөг гэсэн гурван өөр төсөвт өртөг байна. Үнэлгээний хорооны гишүүдийн саналаар ТББ-т “ирүүлсэн үнийн санал нь 90 хувиас бага тохиолдолд ирүүлсэн үнийн саналыг “хэт бага” гэж үзэн тендерээс татгалзана” гэсэн заалт оруулсан нь дээрх төсөвт өртгүүдийн чухам алины 90 хувь болох нь тодорхойгүй байна.*
- 1.27 Цаашид хэт бага үнийн санал ирүүлсэн этгээдийн тендерээс татгалзах нөхцөлийг ТББ-т заахдаа төсвийн тухай хуулиар баталсан төсөвт өртөг ба экспертизээр баталсан төсөвт өртгийн алийг шалгуур үзүүлэлт болгохыг тодорхой болгон журамлах шаардлагатай байна.
- 1.28 БСШУЯ-ны ТНБД-ын 2010 оны 101 дүгээр тушаалаар баталсан “Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахад дотоодод баримтлах аргачлал”-аар санхүү хөрөнгө оруулалтын газрын нэгдсэн мэдээллийн сан, худалдан авах ажиллагааны зохицуулалт хариуцсан мэргэжилтэн болон үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн худалдан авах ажиллагаанд оролцох үүргийг тодорхойлсон байна.
- 1.29 Энэ аргачлалаар үнэлгээний хороо байгуулагдахаас эхлэн гүйцэтгэгчтэй гэрээ хийх хүртэлх үйл ажиллагааг зохицуулжээ. Харин гэрээ дүгнэх үеийн гүйцэтгэгчтэй хариуцлага тооцох, эцсийн санхүүжилт олгох, барилгын баталгаат засварын хугацааны барьцааг хаана, хэрхэн байршуулах талаарх харилцааг орхигдуулсан байна.
- 1.30 Энэ нь баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан эвдрэл гэмтэл гарах тохиолдолд түүнд засвар хийх хөрөнгийн найдвартай эх үүсвэргүй болгож байна.

- 1.31 2010 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 78 гэрээний нөхцөлд хийсэн судалгаагаар нийт гэрээнд хүлээх хариуцлага, гүйцэтгэлийн баталгаа болон баталгаат засварын барьцааны талаар тусгасан байна.
- 1.32 Гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү байхаар тогтоож ажил гүйцэтгэх гэрээнд тусгасан боловч нийт гүйцэтгэгчийн дөнгөж тал хувь нь гүйцэтгэлийн баталгаа хөрөнгийг арилжааны банкинд байршуулсан байна. Гүйцэтгэлийн баталгаа болох мөнгөн хөрөнгийг гэрээнд заагдсан ажил дууссан тухай улсын комиссын мэдэгдэл гарснаас хойш 28-30 хоногийн дараа чөлөөлөх нөхцөлтэй банкны баталгаа гаргуулан авчээ.
- 1.33 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43. 6^б-д заасны дагуу үнийн дүнгийн 5 хувийг барьцаалах нөхцөлийг гэрээнд тусгадаг боловч барьцаа хөрөнгийг байршуулаагүй байна.
- 1.34 Баталгаат засварын барьцааг байршуулахгүй байгаагаас гарч болох үр дагаврыг анхаарч цаашид баталгаат засварын барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулж байхаар журамлах шаардлагатай байна.
- 1.35 БСШУЯ барилга объектыг шинээр барих, өргөтгөх талаархи салбарын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, УИХ-ын гишүүдийн санал санаачлагаас эхлэн улсын комиссын акт гарч ашиглалтад оруулах хүртэлх үзүүлэлтүүдийг багтаасан мэдээллийн нэгдсэн санг салбарын хэмжээнд бий болгон баяжуулах ажлыг 2008 оноос хэрэгжүүлж байна.
- 1.36 Энэ нь хөрөнгө оруулалтын талаархи мэдээллийг авах, нэгтгэн дүгнэхэд дөхөмтэй, бусад салбарт нэвтрүүлж болох дэвшилттэй ажил болсон бөгөөд цаашид өргөжүүлэх хэрэгтэй юм.

Өмнөх онуудын төлөвлөлтийн алдаа хөрөнгө оруулалтын цаашдын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна

- 1.37 Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд ерөнхий боловсролын 13 сургуулийн хичээлийн байрыг шинээр ашиглалтад оруулж, суудлын тоог 4668-аар, 9 дотуур байрыг ашиглалтад оруулж, орны тоог 1045-аар, 29 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулж, орны тоог 2640-өөр, 13 соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, суудлын тоог 2890-ээр, 7 спорт заалыг ашиглалтад оруулж, талбайг 2016 м² -аар тус тус нэмэгдүүлжээ.
- 1.38 Мөн нийт 201 сургууль, цэцэрлэг, соёлын төв, дотуур байр, спорт заалыг улсын төсвөөр, 8 сургуулийн хичээлийн байрыг “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3” төслийн санхүүжилтээр засварласан байна.
- 1.39 Хөрөнгө оруулалтын үр дүнд цэцэрлэгийн хамран сургалт 3.4 хувиар, бага боловсролын хамран сургалт 0.2 хувиар, суурь боловсролын хамран сургалт 0.1 хувиар тус тус өссөн байна.
- 1.40 Салбарын хэмжээнд дээрх төсөл арга хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 73.5 тэрбум төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийн 97.4 хувийг эзэлж байна.

⁶ Бараа ажил үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг гэрээнд тусгаж болно.

1.41 БСШУЯ гэрээний үүргээ биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдсан гүйцэтгэгч нараас хийсэн ажил, олгосон санхүүжилтийн зөрүүг нэхэмжлэхдээ экспертизийн дүгнэлт гаргаагүй, дүгнэлт гаргаж зөрүүг тогтоосон боловч нэхэмжилж аваагүй байна.Тухайлбал,

- "Монгени" сургуулийн өргөтгөл, спорт заалны барилгыг 2009 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ашиглалтад оруулах 575.6 сая төгрөгийн гэрээг "МБҮ" ХХК-тай 2008 онд байгуулсан боловч графикийн дагуу ажлаа гүйцэтгээгүй тул ТНБД-ын тушаалаар гэрээ цуцлах хариуцлага ногдуулсан байна. Дахин тендер зарлаж, "Зос трейд" ХХК-тай БУА-ыг 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүлээлгэн өгөх 350.0 сая төгрөгийн гэрээг байгуулсан ч мөн л хугацаандаа ашиглалтад ороогүй.
- Уг барилгын төсөвт өртөг 629.0 сая төгрөг бөгөөд анхны гүйцэтгэгч "МБҮ" ХХК-д 293.7 сая, шинээр шалгарсан "Зос трейд" ХХК-д 313.0 сая, нийт 606.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь төсөвт өртгийн 96.5 хувийг эзэлж байгаа боловч БУА 56.0 хувийн гүйцэтгэлтэй.
- БСШУЯ-ны БЗА-наас "МБҮ" ХХК-тай гэрээ цуцалсан ч хийсэн ажил, олгосон санхүүжилтийн зөрүүд 50.0 сая төгрөг нэхэмжилсэн нь үндэслэл муутай байх тул мэргэжлийн экспертизийн дүгнэлтээр баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.
- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, спорт заалны барилгын гүйцэтгэгчээр БСШУЯ-наас 2006 онд зарласан тендерт шалгарсан "Дэлгэр интернэйшнл" ХХК 2007 оны 8 дугаар сарын 15 -ны өдөр ашиглалтад өгөх 585.0 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч, 2007 оны 8 дугаар сарын 21-нд спорт заалны хэмжээг томсгох 56.0 сая төгрөгийн, 2009 оны 8 дугаар сарын 15 хүртэл хугацааг сунгаж, 275.4 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, хичээлийн байрыг улсын комисст хүлээлгэн өгсөн,
- Спорт заалны барилгад "Дэлгэр интернэйшнл" ХХК материалын үнийн зөрүү 140.0 сая төгрөг нэхэмжилснийг УИХ-аас 21.0 сая төгрөг болгон баталсныг үлдсэн ажилд хүрэхгүй гэж үзэн спорт заалны БУА-ыг гүйцэтгэх боломжгүйгээ мэдэгдэж, гэрээ цуцлагдсан,
- Спорт заалны суурь тавьсан боловч баганын тэнхлэг зөрсөн, хийсэн ажил нь авсан санхүүжилтээсээ 115.2 сая төгрөгөөр дутуу болохыг улсын экспертизээр тогтоосон атал БСШУЯ уг компаниас нэхэмжилж аваагүй тул албан шаардлага хүргүүлэв.
- Орон нутагт эрх шилжүүлж "Суварга Эв" ХХК-тай спорт заалны суурийг шинэ зургийн дагуу алдааг залруулан 2010 оны 10 дугаар сарын 15-ны дотор ашиглалтад оруулах 275.0 сая төгрөгийн гэрээг Хэнтий аймгийн ЗД хийсэн боловч хугацаандаа ашиглалтад ороогүй,
- Улсын төсөв, Дэлхийн зөн ОУБ-ын хамтарсан санхүүжилтээр баригдаж буй Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга "Жаргалант луу" ХХК-тай 2007 онд байгуулсан гэрээ ёсоор 2008 онд ашиглалтад орох ёстой ч ороогүй.
- 2009 онд нэмэлт гэрээ хийж, 61.0 сая төгрөгийн санхүүжилт нэмсэн, 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацааг сунгасан ч дуусаагүй, улмаар 2010 онд ажлаа орхисон тул ТНБД-ын тушаалаар гэрээг цуцалсан,
- Гэвч БСШУЯ "манай яам санхүүжилт саатуулж гэрээний үүргээ зөрчсөн тул алдагдал хүлээх магадлалтай" гэдэг үндэслэлээр тооцоо хийгээгүй,

- Дахин зарласан тендерт “Ганмөнхжин” ХХК шалгарч, 2010 онд Дэлхийн зөн ОУБ-ын Монголын талын хөрөнгөд батлагдсан 100.0 сая төгрөг, улсын төсвийн 130.0 сая төгрөг, нийт 230.0 сая төгрөгийн гэрээ хийсэн байна.

1.42 Өмнөх жилүүдэд барилга объектын төлөвлөлттэй холбоотой асуудлыг бүрэн шийдээгүй байхад хөрөнгө батлан барилгын ажлыг эхлүүлснээс хугацаандаа ашиглалтад орохгүй он дамжин сунжрах явдал гарч байна.Тухайлбал,

- 2008 оноос эхэлсэн Уламжлалт анагаах ухааны корпорацийн эмийн үйлдвэрийн барилгын (гүйцэтгэгч "Лайт Хаус" ХХК) цахилгааны техникийн нөхцөл нь шинээр байгуулагдах дэд станцаас холбох байсан боловч уг дэд станц баригдаагүйгээс 3 удаагийн өөрчлөлтөөр 450 метрийн цаана байх 115 дугаар сургуулиас хангах болж, хөрөнгө нэмж шаардагдан хугацаа алдсан,
- Бохир усны техникийн нөхцөлд заасан цэг нь хувь хүний эзэмшлийн шугам, худаг байснаас УСУГ-т асуудлыг дахин тавьж уг хүнтэй тохирсны дагуу БСШУЯ эдгээр ажлыг гүйцээж 2011 оны 5 дугаар сарын 1-ний дотор хүлээлгэн өгөх 103.2 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулсан,
- 2008 оноос 928 хүүхдийн суудалтай байхаар төлөвлөгдсөн БГД-ийн 1-4 дүгээр хороонд баригдах сургуулийн газрын зөвшөөрлийг хувийн компанийн газарт давхардуулж олгосноос цуцалж, шинээр олгосон газрын хэмжээнд тохируулан 640 суудалтай болгож зураг төсөв дахин хийлгэсэн, БСШУЯ гүйцэтгэгч “Цаст констракшн” ХХК-тай 2010-2012 онд гүйцэтгэх 1699.9 сая төгрөгийн гэрээ байгуулж 2010 онд 800.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, ажлын гүйцэтгэл 49.6 хувьтай байгаа,
- 2008 оноос эхэлсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Шанд баг 120 ортой цэцэрлэгийн барилгыг (гүйцэтгэгч “Төмөрхүлэг” ХХК) DAKON-РТЕ маркын 2 ширхэг цахилгаан зуухаар халаахаар зураг хийсэн боловч түүний ойролцоо хүчин чадал хангагдах дэд өртөө байхгүйгээс ердийн галладаг зуухаар түр халааж байгаа,
- 2007 оноос эхэлсэн Дэлхийн зөн ОУБ-тай хамтарсан хөрөнгө оруулалттай СХД-ийн 24-р хорооны 100 ортой цэцэрлэгийн барилгыг (гүйцэтгэгч “Монгол Дайвин ХХК”) анх 25 дугаар хорооны нутагт барихаар төлөвлөсөн боловч 104 дүгээр сургуультай газрын маргаан үүсч, батлагдсан төсвөө ондоо зарцуулах үүднээс 2009 оноос 24 дүгээр хороонд уулын бэлд барьсан ч гадна цахилгааны хөрөнгийн асуудал шийдэгдээгүй,
- 2007 оноос эхэлсэн СХД-ийн 38-р цэцэрлэгийн барилгыг (гүйцэтгэгч “Тобем ХХК”) гадна цахилгааны эх үүсвэр шийдэгдээгүйгээс ашиглалтад ороогүй,
- Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 140 ортой цэцэрлэгийн барилгын (гүйцэтгэгч “Синчи Ойл” ХХК) анхны гэрээний 550.6 сая төгрөгийн дүнд гадна шугамыг оруулаагүй тул 2010 онд 61.4 сая төгрөгөөр гүйцээсэн,
- 2008 оноос эхэлсэн Ховд аймгийн Жаргалант сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг (гүйцэтгэгч “Ховдтулга” ХХК) 2010 онд ашиглалтад өгөх ёстой ч газрын байршил өөрчлөгдсөнөөс дэд бүтцийн техникийн нөхцөлүүдэд нөлөөлснөөс хугацаа алдсан, (аймгийн цэвэр бохир усны сүлжээ ашиглалтад ороогүй) 2010 оны 7 дугаар сард хийсэн нэмэлт гэрээгээр спорт заал барих болсон,

- СБД-ийн 16 дугаар хорооны цэцэрлэгийн барилга (гүйцэтгэгч “Назу” ХХК) 2009 оноос эхэлсэн, газрын захирамж нь уулын бэлд, өндөр хүчдэлийн шугамын дор гарснаас цахилгааны техникийн нөхцөл өгөөгүй, газрын захирамж дахин гарч хэрэгжсэн,
- СБД-ийн 17 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын цахилгааны техникийн нөхцөл 16 дугаар хорооны нутагт гарснаас залруулахад хугацаа алдсан,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн барилга 2010 онд ашиглалтад орох ёстой ч барилгын сууринд цууралт үүсч, МХЕГ-ын дүгнэлтээр лабораторийн шинжилгээ хийлгэж, суурийн бэхлэгээний зураг нэмж хийлгэснээс цаг алдсан, бохир усны техникийн нөхцөл нь хувийн орон сууцны шугаманд холбохоор гарснаас 15.0 сая төгрөгийг гүйцэтгэгч “Ханхайрхан” ХХК төлж холбосон, хүйтний улирал эхэлснээс ДШСГ-аас халаалт өгөөгүй хавар болохыг хүлээж байгаагаас дотор заслын ажил зогссон,
- БЗД-ийн 14 дүгээр хорооны 100 ортой цэцэрлэгийн барилгын ажил 2007 оноос төлөвлөсөн боловч байршил өөрчлөгдөн 13-р хороонд газрын (“Хөхтэнгэр хөвсгөл” ХХК) захирамж гарч, техникийн нөхцөл авахад хугацаа алдсан байна.

1.43 2010 онд барилга байгууламжийн гүйцэтгээгүй ажилд 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлсний дотор батлагдсан төсвийг алдахгүйн үүднээс оны эцэст гэрээ байгуулж 1.5 тэрбум төгрөг олгосон байна. Тухайлбал,

- “Оюутны байр-1000” хөтөлбөрийн хүрээнд БЗД-т барих барилгын гүйцэтгэгчээр шалгарсан “Хөвсгөл геологи”, “Хөхий хан” ХХК-уудтай оны эцэст гэрээ хийж 1000.0 сая төгрөгийг бүрэн олгосон,
- БЗД-ийн 4, 7 дугаар хорооны 100 ортой цэцэрлэгийн барилгуудад 2010 онд 505.0 сая төгрөг батлагдсан боловч 4,11-р хороо болж байршил өөрчлөгдсөн, 11 дүгээр хорооны цэцэрлэгийг “Хүжийн гал” ХХК-тай 250.0 сая, 4 дүгээр хорооны цэцэрлэгийг “Баз Констракшн” ХХК-тай 248.9 сая төгрөгөөр хуанлийн 60-180 хоногт барих гэрээг 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулж, батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон,
- Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 250 хүний суудалтай Соёлын төвийн барилгын гүйцэтгэгч “Оорцог-Уул” ХХК-иас ирүүлсэн 199.4 сая төгрөгийн гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн боловч уг гүйцэтгэл хуурамч болох нь илэрснээс ТНБД-ын тушаалаар гэрээ цуцалж, хууль хяналтын байгууллагад шилжсэн, экспертизийн тооцоогоор 49.4 сая төгрөгийн ажил хийгдсэн нь тогтоогоод байна.

1.44 Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зарим гүйцэтгэгчийн хийсэн ажлын чанарт тус яамны БЗА-ны инженерүүд хяналт тавьж зарим зөрчил дутагдлыг засуулж иржээ.(Хавсралт № 3)

1.45 Анх тендерт хэт бага үнийн саналаар орж шалгаран гэрээ байгуулж, дараа нь үнийн зөрүү нэхэмжлэх замаар төсөвт өртгийг нэмэгдүүлэх, зарим барилгад хийсэн улсын экспертизийн төсвийн тооцоо хоорондоо хэт зөрүүтэй гарах тохиолдол байна.Тухайлбал,

- БСШУЯ Говь-Алтай аймгийн "Алтай" чуулгын БУА-ыг 1830.0 сая төгрөгөөр 474 хоногт хийх гэрээг 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдөр "Заг" ХХК-тай байгуулж, 2009 онд үнийн зөрүүд 149.1 сая төгрөг батлагдсныг олгосон ч дахин санхүүжилт нэхэмжилж, 2009-2010 онд хоёр удаа экспертиз ажиллуулж, улсын экспертиз П.Ёндонгомбо авсан санхүүжилт, хийсэн ажлын хэмжээг тогтоосон бол улсын экспертиз Б.Оюун цаашид 2606.1 сая төгрөг нэмж шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна. Зурагт өөрчлөлт ороогүй атал энэ нь "Барилгын төсөв, хөрөнгийн үнэлгээ" ХХК-ийн 2007 онд зохиосон анхны төсөвт (1855.9 сая) өртгөөс хэт өндөр байна.
- Одоогоор БУА-ын гүйцэтгэл 44.0 хувьтай, 2010 онд 255.0 сая, 2011 онд 1000.0 сая төгрөг батлагдсан боловч нийт санхүүжилтийн хэмжээ бүрэн батлагдаагүйгээс гэрээг шинэчлэн хийгээгүй,
- Увс аймгийн техник, технологийн "Улаангом" коллежийн барилгын шинэчлэлийг 730.0 сая төгрөгөөр хийж, 2008 онд ашиглалтад өгөх гэрээг 2007 онд "Дэлгэр констракшн" ХХК-тай хийсэн ч өнөө хүртэл дуусаагүй, 2009 онд үнийн зөрүүд батлагдсан 39.1 сая төгрөгийг аваагүй, улмаар 2010 онд хөрөнгө батлагдаагүй,
- Уг барилгыг дуусгахад 485.3 сая төгрөг шаардлагатай гэсэн экспертизийн дүгнэлт гарч, 2011 онд 450.0 сая төгрөг батлуулж, 2011 оны 8 сард ашиглалтад өгөхөөр нэмэлт гэрээ хийсэн,
- Хэнтий аймгийн Бор Өндөр тосгоны сургуулийн дотуур байрны 541 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын гүйцэтгэгч "Мон инж трейд" ХХК-д 2010 онд хөрөнгө дутагдсан гэсэн шалтгаанаар үнийн зөрүүд 61.0 сая төгрөг нэмж өгсөн,
- Хөвсгөл аймгийн Рашаант сумын цэцэрлэгийн БУА-д 2008 онд МУХС-гаас 120.0 сая төгрөг батлагдсан, 2009 онд 194.8 сая төгрөг олгож төсвийн тухай хуулиар баталсан 314.8 сая төгрөгийг зарцуулсан, 2010 оны төсвийн тодотголоор төсөвт өртгийг 495 сая төгрөг болгон нэмэгдүүлж, тухайн онд 50.0 сая, 2011 онд 131.0 сая төгрөг батлагдсан байна.

1.46 Он дамжсан барилга байгууламжийн барих гэрээт хугацаанд төсөв батлахгүй жил өнжих буюу төсвийн тухай хуулиар хасагдаж, тодотголоор нэмж батлагдаж байгаа нь ашиглалтад орох хугацаа хойшлоход зарим талаар нөлөөлж байна. Тухайлбал,

- Архангай аймгийн Багшийн коллежийн барилгыг 2008 оны төсвийн тухай хуульд 300.0 сая төгрөгийн нийт төсөвт өртөгтэй, тухайн онд 300.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан. "Алтанбулаг трейд" ХХК 2796.0 сая төгрөгөөр 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2010 оны 8 дугаар сарын 10-ны хооронд барихаар гэрээ байгуулсан ч ашиглалтад ороогүй,
- Үүнд 2010 онд төсвийн тухай хуулиар хөрөнгө батлагдаагүй, харин төсвийн тодотголоор 500.0 сая, 2011 онд 1796.0 сая төгрөг батлагдсан бөгөөд ажлын гүйцэтгэл 44 хувьтай байгаа,
- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 150 ортой цэцэрлэгийн барилга анх 2008 оноос 50.0 сая төгрөгөөр эхэлсэн, 2009- 2010 онд төсвийн тухай хуулиар төсөв батлаагүй, 2010 оны төсвийн тодотголоор 350.0 сая, 2011 оны улсын төсвийн тухай хуулиар 340.0 сая төгрөг батлагдснаар нийт 740.0 сая төгрөг батлагдаад байна .

1.47 Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажил холбогдох баримт бичигт заасан хүчин чадалдаа хүрээгүй тохиолдол илэрсэн байна. Тухайлбал,

- *Хэнтий аймгийн Тэмүүжин цогцолбор сургуулийн 920 хүүхдийн суудалтай барилга 2007-2009 оны улсын төсвийн тухай хууль, гүйцэтгэгч Харчонот ХХК-тай 2007 онд байгуулсан гэрээ болон 2009 онд үйлдсэн улсын комиссын актаар 920 суудалтай байхаар тусгагдсан байтал Хэнтий аймаг зураг төсвийг 630 хүүхдийн суудалтай байхаар хийлгэж, уг зургаар БСШУЯ бариулсан байгаагийн дээр засвар хийх шаардлагатай болсон тухай ашиглагч байгууллагаас мэдээлсэн байна.*

Бүлэг 2:

ЭМ-ИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

Зураг төсөө бэлэн болох үед төсөвт өртөг нэмэгдэж байна.

- 2.1 “Зарлагын хязгаар батлах тухай” ЗГ-ын 2009 оны 220 дугаар тогтоолд ЭМ-ийн салбарын 2010 оны хөрөнгийн зардлын дээд хязгаарыг 24.0 тэрбум төгрөг байхаар тогтоожээ.
- 2.2 Сангийн сайдад хүргүүлсэн “ЭМ-ийн ТЕЗ-ийн 2010-2012 оны төсвийн төлөвлөгөөний төсөл”-д тус салбарт 248.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий шилжих болон шинээр эхлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн онд 46.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийх санал тусгасан байна.
- 2.3 ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуулийн төсөлд дээрх саналыг 27.7 тэрбум төгрөг болгон хянаж, УИХ-аас хөрөнгө оруулалтын хэмжээг төсвийн тухай хуулиар 29.1 тэрбум төгрөг, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 103.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг 43.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.
- 2.4 ЭМС-ийн салбарт 2010 онд хөрөнгө оруулалтаар 43,3 тэрбум төгрөг батлагдаж 40,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн ба батлагдсан нийт санхүүжилтийн 94 хувийг зарцуулжээ.
- 2.5 Энэ нь ЭМЯ-ны анхны боловсруулсан саналаас 6,1 хувиар буурсан байна. 2010 онд батлагдсан хөрөнгө оруулалтын зориулалтыг харуулбал,

Хөрөнгө оруулалт	Дүн (сая төг)	Хувийн жин
Шилжих барилга	7111.8	16.4
Шинээр эхлэх барилга	19089.0	44.0
Их засвар	7885.0	18.2
Тоног төхөөрөмж	9261.1	21.4
Дүн	43346.9	100

- 2.6 Барилга байгууламж, их засварын хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө улсын хэмжээнд тусламж үйлчилгээ үзүүлдэг үндэсний төв, нэгдсэн эмнэлэг, аймаг, дүүрэг, сумдын эмнэлэг, хүн амын өсөлт, эрүүл зан үйлийг дэмжих зорилгоор төрөхийн эмнэлэг, хүүхдийн эмнэлэг, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхийн тулд спортын цогцолбор, зал танхим зэргийг шинээр барих, өргөтгөх, засварлахад түлхүү анхаарсан байна.
- 2.7 2010 оны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн барилга байгууламжийг бүтцээр нь авч үзвэл 40.3 хувийг I шатлалын эмнэлэг, 20.9 хувийг II шатлалын эмнэлэг, 6 хувийг III шатлалын эмнэлэг, 22.4 хувийг спортын цогцолбор, 10.4 хувийг бусад төсөл, арга хэмжээ эзэлж байна. Эндээс үзэхэд хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжийн ихэнх хувь нь I шатлалын эмнэлэг буюу сум, өрх, сум дундын эмнэлгийг шинээр барьж байгуулах, өргөтгөх, засварлахад зориулагдсан байна.

- 2.8 Аймгуудын эмнэлгийн орны тоог нийт хүн амын тоотой харьцуулсан судалгаагаар Говь-Алтай, Говьсүмбэр аймгуудад 1000 хүн тутамд ногдох орны тоо хамгийн өндөр буюу 7,7-8,0 байхад Төв, Хөвсгөл, Орхон зэрэг аймгуудын хувьд уг үзүүлэлт хамгийн бага буюу 1000 хүнд 4,8-5,1 ор ногдож байна.
- 2.9 МУ-ын 2009 оны статистикийн эмхтгэлд 1000 хүнд ногдох орны тоо улсын хэмжээнд 6,5 байна.

№	Аймаг	Хүн амын тоо /мян.хүн/	ЭМБ-ын тоо /орны тоогоор/	1000 хүнд ногдох ор
1	Архангай	92,5	574	6,2
2	Баян-Өлгий	101,9	596	5,8
3	Баянхонгор	85,4	499	5,8
4	Булган	62,3	371	6,0
5	Говь-Алтай	59,4	460	7,7
6	Говьсүмбэр	13,3	106	8,0
7	Дархан-Уул	90,0	507	5,6
8	Дорноговь	58,3	356	6,1
9	Дорнод	73,6	480	6,5
10	Дундговь	47,7	298	6,2
11	Завхан	79,3	530	6,7
12	Орхон	83,1	420	5,1
13	Өвөрхангай	117,5	637	5,4
14	Өмнөговь	49,3	271	5,5
15	Сүхбаатар	55,0	317	5,8
16	Сэлэнгэ	103,5	646	6,2
17	Төв	88,5	423	4,8
18	Увс	78,8	478	6,1
19	Ховд	88,5	558	6,3
20	Хөвсгөл	124,1	604	4,9
21	Хэнтий	71,5	434	6,1
	Аймгийн дүн	1623,5	9,565	5,9

2.10 Төсвийн хөрөнгө оруулалтад зураг төсөвгүй барилга байгууламжийг төлөвлөснөөс гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлагдсаны дараа зураг төсөв хийгдэж, төсөвт өртөг нэмэгдэж байна.

2.11 2010 оны хөрөнгө оруулалтаар батлагдсан зарим барилга байгууламжийн хувьд барилга угсралтын ажлын явцад батлагдсан төсөвт өртгөөс 2.1 тэрбум төгрөгөөр анхны төсөвт өртөг нь нэмэгджээ. Тухайлбал,

- **2008 оноос эхэлсэн Төв аймагт** баригдаж буй 700 хүний суудалтай спорт цогцолборын барилга 2010 оны 8-р сард дуусах ёстой ч ажлын гүйцэтгэл 92 хувьтай байна. Санхүүжилтийг “Үүрэг трейд” ХХК-д цаг алдалгүй шилжүүлж байсан боловч гүйцэтгэгчийн дотоод зохион байгуулалт, ажиллах хүчний ур чадвараас шалтгаалан хугацаандаа ашиглалтад ороогүй, төсөвт өртөг нь 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн,
- 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **Ховд аймгийн Жаргалант** суманд баригдсан 50 ортой төрөх эмнэлгийн барилга улсын төсөвт батлуулсны дараа зураг төсөв нь хийгдэж 651.4 сая төгрөгөөр төсөвт

- *өртөг нэмэгдэж, гэрээний дүнд өөрчлөлт орсон,*
- *Завхан аймгийн Шилүүстэй сумын 20 ортой эмнэлгийн барилгад 500 сая төгрөг батлагдсан боловч төсөвт өртөг 660 сая төгрөг болж өссөн,*
- *Хэнтий аймгийн Өндөрхаан хотын 20 ортой уламжлалт анагаах ухааны эмнэлгийн барилгад 494,5 сая төгрөг батлагдсан боловч төсөвт өртөг 679,1 сая төгрөг болж 2011 онд дамжсан байна.*

2.12 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус шинж чанартай зарим зардлыг санхүүжүүлсэн байна. Тухайлбал,

- *ЭНЭШТ-д нярайн мэс заслын хэсэг шинээр байгуулахад 350.0 сая төгрөг баталж, их засварын ажилд 50.0 сая, нярайн тоног төхөөрөмжид 300.0 сая төгрөг зарцуулах ёстой ч 30.0 сая төгрөгийг нэг удаагийн хэрэгсэлд зарцуулсан нь урсгал зардлын шинжтэй,*
- *ЭМЯ-ны их засварт 5,3 тэрбум төгрөг батлагдсаны дотор МУ-ын буцалтгүй тусламжаар БНАЛАУ-д барьсан Найрамдал эмнэлгийн засварт 300 сая төгрөг баталсан нь гадаадад үзүүлсэн тусламж гэсэн ангилалд хамрагдахаар байна.*

2.13 Орон нутагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтыг аймгийн Засаг дарга зориулалтыг нь өөрчилсөн зөрчил илэрлээ. Тухайлбал,

- ***Баянхонгор аймагт** эмнэлгийн ажилчдын орон сууц барихад зориулан баталсан 477.0 сая төгрөгөөс аймгийн ЗД-ын захирамжаар 177.0 сая төгрөгийг орон сууцны дэмжлэг авсан эмнэлгийн ажилтнуудыг оруулахаар гэрээ хийж “Хөх бүрдний эх” ХХК-д шилжүүлж, бусад байгууллагын төрийн албан хаагч нарт 300.0 сая төгрөгийг ажилласан жилээс нь хамааруулан бэлнээр олгосон нь төсвийн тухай хууль зөрчиж хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилсөн байна.*

2.14 Хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийг төлөвлөх шатанд зураг, төсөв, газрын захирамж, техникийн нөхцөлүүдийг нэг мөр шийдвэрлүүлээгүйгээс барилгын ажил эхэлж чадахгүй, эсвэл дууссан барилгыг ашиглалтад оруулах боломжгүй болгож байна. Тухайлбал,

- ***ХУД-т** баригдах 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгад зориулж НЗД-ын 2008 оны 406 дугаар захирамжаар 0,2 га газрыг олгосон нь өөр компанийн газартай давхардсанаас ажил эхлээгүй,*
- *170 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сэлэнгэ аймгийн Мандал сумын эмнэлгийн барилгын ажил бүрэн хийгдэж дууссан ч барилгыг инженерийн шугам дээр барьсан учир улсын комисс хүлээж аваагүй байна.*

Тендерийг хугацаа алдаж зарласнаас гүйцэтгэгчтэй байгуулах гэрээ оройтож, бодит бус гүйцэтгэлээр санхүүжилт олгож байна

2.15 93 барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдаж авах 30 ажилд нээлттэй тендер зарлагдсан байна. Харин 55 барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдаж авах 6 ажилд харьцуулалтын аргыг ашигласан байна.

- 2.16 ЭМЯ тендерийн хуулийн 48.5⁷-дахь заалтыг хэрэгжүүлээгүй бөгөөд СЯ-ны худалдан авах ажиллагааны цахим хуудаст зөвхөн 8 тендерийн үр дүнг мэдээлжээ. Гэсэн ч СЯ тус яамны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 61 оноогоор хангалттай гэж үнэлжээ.
- 2.17 Тендерт оролцогчдоос ирүүлсэн 13 гомдлыг СЯ хянаж 7 гомдол үндэслэлтэй байсан тул дахин үнэлгээ хийсэн байна.
- 2.18 ЭМ-ийн салбарт 2010 онд 123 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтаар 100 тэрбум, 61 удаагийн харьцуулалтын аргаар 1.8 тэрбум, 2 удаагийн шууд гэрээгээр 850 сая, нийт 186 удаагийн 102.6 тэрбум төгрөгийн худалдан авалт хийжээ.
- 2.19 Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн нийт худалдан авалтын 97.5 хувийг нээлттэй тендерээр, 1.7 хувийг харьцуулалтын аргаар, 0.8 хувийг шууд гэрээгээр хэрэгжүүлсэн байна.
- 2.20 ЭМ-ийн салбарын зарим нэг төсөл, арга хэмжээнд тендерийн хуулийн 8.4⁸, 8.7.1⁹ дэх заалтыг баримтлалгүй тендер шалгаруулалтын аргыг буруу сонгосон байна. Тухайлбал,

- 165 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЗГ-ын VIII байрны их засварын ажлыг хэд хэдэн багцад хувааж харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан,
- Улсын хэмжээнд чихрийн шижин өвчинтэй тэмцэх 400 сая төгрөгийн арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдаж авах тоног төхөөрөмжийг 5 багц болгон ХТШ-ын аргыг сонгосон байна.

- 2.21 Гүйцэтгэгчтэй хийх гэрээг холбогдох загварын дагуу байгуулж, гэрээнд хариуцлагыг зааж өгч байгаа боловч хэрэгжих хугацааг гэрээнд бодитой бус зааж байгаа нь гүйцэтгэгчтэй хариуцлага тооцох боломжгүй болгож байна. Тухайлбал,

- ХУД-т баригдаж буй Олимпийн хотхоны гадна инженерийн шугам сүлжээ, зам талбай тохижилт, автомашины зогсоолын ажилд 2010 онд 2.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч уг ажил 2010 онд дуусаагүй байна. Уг ажлыг гүйцэтгэхээр 3 багцад 3 компани ("Беринг" ХХК, "Шинэ-очир" ХХК, "ЧММ" ХХК) шалгарч 2010 оны 10 сард гэрээ байгуулжээ. Уг ажлын явц 80 хувьтай байгаа боловч 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2010 онд олгожээ. Тендерийг оройтож зарлан 2010 оны 10 сард гэрээ байгуулж гэрээнд 2010 оны 12 сарын 20-нд дуусгахаар хугацаа заасан байна.
- **Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цэвэрлэх байгууламжийн засварын ажилд 2010 онд 950 сая төгрөг төсвийн тодотголоор батлагджээ. НТШ-аар "ЧММ" ХХК шалгарч 2010 оны 12-р сарын 15-ны өдөр гэрээ байгуулж, засварын ажлыг 2010 оны 12-р сарын 30-нд дуусахаар гэрээнд заажээ.**

⁷ "Захиалагч ХАА-ны төлөвлөгөөг тухайн жилийн эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ"

⁸ "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно",

⁹ "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгоно."

Орон нутагт эрх шилжсэн ажлын чанар хангалтгүй, хяналт сулаас барилгын ажил сунжирч байна

2.22 2010 онд ашиглалтад орох барилгын ажил хугацаандаа дуусалгүй он дамжсан, улсын комисст хүлээлгэж өгөөгүй, их засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн зэрэг зөрчлүүд гарсаар байна. Ийм барилга байгууламжийн ихэнх нь орон нутагт эрх шилжсэн ажлууд байгаа бөгөөд тендер оройтож зарлагдсаны улмаас хүйтний улирал эхэлж барилгын ажил зогссон байна. Тухайлбал,

- 219.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Дундговь аймгийн эмнэлгийн их засварын ажлын гүйцэтгэгч “Немон” ХХК-ийн буруугаас ажил дуусаагүй, гүйцэтгэл 60 хувьтай, эмнэлгийн зөвхөн 1 корпус л засвар хийсэн нь чанаргүй болсон,
- 500 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өвөрхангай аймгийн **Хужирт** суманд баригдах сум дундын эмнэлгийн барилгын гүйцэтгэгч “Аж констракшн” ХХК-тай 2010 оны 7-р сарын 19-нд гэрээ хийсэн, ажлын явц 70 хувьтай байгаа,
- Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 20 ортой эмнэлгийн БУА 2010 онд дууссан боловч улсын комиссын гишүүд бүрдээгүй шалтгаанаар одоо хүртэл улсын комисс хүлээж аваагүй,
- **Орхон** аймгийн Биеийн тамир, спортын газрын барилгын засварын ажилд 49.2 сая төгрөг батлагдаж Цамхаг өргөө ХХК 42.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Гэвч хүчтэй шороон шуурганы үеэр барилгын дээвэр хийсч унаснаас ОБЕГ-ын шийдвэрээр 40 сая төгрөгөөр дээврийн засвар хийгдсэн нь чанаргүй болсон бөгөөд дотор заслын ажил дутуу байхад техникийн комиссын акт үйлдэн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн,
- **Өвөрхангай аймгийн Богд** сумын эмнэлгийн барилгын бохирын цооног, сантехникийн ажил бүрэн дууссан боловч цэвэр усны гүний худгийг 29 сая төгрөгөөр барихаар гэрээ байгуулсан боловч дуусгаагүй байна.

2.23 Батлагдсан төсвийг бүрэн зарцуулахын тулд бодит бус гүйцэтгэл, банкны баталгаа, бараа материалын худалдан авалтын тайлан гаргаж санхүүжилтийг оны эцэст гүйцэтгэгчид шилжүүлдэг явдал зогсохгүй байна.

2.24 2010 онд барилга байгууламжийн бодит бус гүйцэтгэлд 6,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг оны эцэст гүйцэтгэгчид шилжүүсэн байна. Тухайлбал,

- Нийт 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй БЗД-т баригдах сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн БУА-д “Шинэ барилга” ХХК-тай 2010 оны 12-р сарын 1-ний өдөр гэрээ байгуулж, материал татан авалтын гүйцэтгэлээр 2010 онд 600 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон,
- ХУД-т баригдах спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч “Үүрэг трейд” ХХК-тай 2010 оны 8-р сарын 19-ний өдөр гэрээ байгуулсан боловч барилгын ажил эхлээгүй, батлагдсан 103.0 сая төгрөгийг барилгын материал худалдан авалтын гүйцэтгэлээр шилжүүлсэн,
- ХУД-т баригдах 300 ортой төрөх эмнэлгийн барилгын зураг төсөв 2009 оны эцсээр дууссан боловч төсөвт 2010 онд 5 тэрбум төгрөг батлагдсан. 19 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй объектын тендерийг 5 тэрбум төгрөгт зарлах боломжгүй болсон тул 2010 оны тодотголоор шинэчлэн батлуулж, Нийслэл Өргөө ХХК (Түншлэгч Пума

Констракшн ХХК) 18.7 тэрбум төгрөгөөр 2010 оны 12-р сарын 27-нд гэрээ байгуулж 2010 оны 2600.7 сая төгрөгийн банкны баталгаагаар санхүүжилтийг шилжүүлсэн,

- **Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цэвэрлэх байгууламжийн** засварын ажилд 2010 онд 950 сая төгрөг төсвийн тодотголоор батлагджээ. “ЧММ” ХХК -тай 2010 оны 12-р сарын 15-ны өдөр гэрээ байгуулж, зураг төслийн тендер зарлагдаж зураг төсөл боловсруулж, хянах хүртэл хугацаа алдсанаас БУА оройтож эхэлсэн байна. Санхүүжилтийг ондоо багтаан зарцуулах үүднээс “ЧММ” ХХК-иар урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулан **842,1** сая төгрөг шилжүүлжээ.

2.25 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн зарим барилга байгууламжийн өмчлөлийн асуудал тодорхой бусаас данс бүртгэлд тусгагдахгүй байх явдал гарч байна. Тухайлбал,

- ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 4 дүгээр төрөхийн барилгын ажил, ХУД-т шинээр баригдсан спорт цогцолборын гадна талбайн тохижилт, БГД-ийн 35 ортой хүүхдийн эмнэлгийн барилга, түүнд зориулсан тоног төхөөрөмж бүртгэлд тусгаагдаагүй байна.

2.26 Барилга байгууламж бүрэн баригдаагүй болон дууссан ч улсын комисс хүлээж аваагүй байхад захиалагч гүйцэтгэгчид санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн байна. Тухайлбал,

- 2007 оноос эхэлсэн **Завхан аймгийн Идэр** сумын 15 ортой эмнэлгийн барилга 2010 онд дуусах ёстой. 2007 онд ЭМСХ-2 төслөөр 50,0 сая, 2008 онд улсын төсвөөс 114,4 сая, 2010 онд 67,5 сая төгрөг тус тус батлагдан нийт 231,9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2007 онд суурийн ажил дуусч, 2008 онд шаардлага хангаагүй тоосго ашигласнаас МХГ-аас зогсоож байсан. Барилгын дээвэр, засал чимэглэл, цахилгаан, дотоод холболт, сантехникийн ажил хийгдээгүй байхад улсын комиссын актыг хуурамчаар гаргаж, 2010 оны санхүүжилтийг гүйцэтгэгч “Алс” ХХК-д бүрэн олгосон,
- **Өвөрхангай аймгийн** Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн паталогийн барилгыг улсын комисс хүлээж аваагүй байхад “Сумпакс” ХХК-д санхүүжилтийг олгосон,
- Нийт 197.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий **Дорноговь** аймгийн Замын-Үүдийн халдвартын эмнэлгийн барилгын гүйцэтгэгч “Ган зосон констракшн” ХХК-д ажлын явц 85 хувьтай байхад санхүүжилтийг 100 хувь олгосон байна.

ДҮГНЭЛТ**Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.**

- Зураг төсөв, техникийн нөхцөл, газрын захирамж бэлэн болоогүй зарим барилга объект хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаснаас хугацаандаа баригдахгүй сунжрах, нэмэлт хөрөнгө шаардагдах, шугам сүлжээ нь дутуу барилга баригдаж, улмаар хөрөнгө оруулалтын үр ашиг буурах нөхцөлийг бий болгож байна.
- Гүйцэтгэгч байгууллага санхүүжилтийг бүрэн авах үүднээс бараа материалын болон ажлын бодит бус гүйцэтгэл гаргасныг санхүүжүүлэх явдал арилахгүй байна.
- Анх тендерт хэт бага үнийн саналаар шалгаран, гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг бодитой бус зааж явцын дунд үнийн зөрүү нэхэмжлэх замаар төсөвт өртгийг нэмэгдүүлэх тохиолдол гарсаар байна. Үүнийг таслан зогсоох зорилгоор тендерийн үнийн доод хэмжээг ТББ-т зааж байгаа боловч төсвийн тухай хуулиар болон экспертизээр баталсан төсөвт өртгийн алийг шалгуур үзүүлэлт болгох ыг журамлаагүй байна.
- Сангийн яамны цахим хуудаст байршуулах босго үнэд хүрсэн худалдан авах ажиллагааны урилгыг дутуу байршуулсан, түүний үр дүнг мэдээлээгүй нь худалдан авах ажиллагааны ил тод байх зарчмыг алдагдуулж байна.
- БЗА-ны инженерүүд явцын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулж ирсэн боловч ажил, үйлчилгээ чанаргүй болох, зурагт заасан барилгын материал, загвар хийцийг өөрчлөх, хугацаандаа ашиглалтад орохгүй он дамжин сунжрах явдал арилахгүй байгаа нь шаардлага хангахгүй гүйцэтгэгч шалгарсан, гүйцэтгэгчийн ажлын хариуцлага, туршлага, санхүүгийн болон ажиллах хүчний нөөцтэй холбоотой байна.
- Улсын төсвөөр гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажил холбогдох баримт бичигт заасан хүчин чадалдаа хүрээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлахдаа хийсэн ажил, түүнд олгосон санхүүжилтийн зөрүүг нарийн тооцож гаргалгүй нэхэмжилсэн буюу тооцсон боловч нэхэмжилж аваагүй байна.
- Захиалагчийн зүгээс хөрөнгө оруулалт, ажил гүйцэтгэх гэрээг хэт ерөнхий хийж байгаагаас үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцоогүй, тендерийн хуульд заасан гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа хоёрыг адилтгаж ойлгосноос гэрээний заалт хэрэгжихгүй байна.

БСШУ-ны санал



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт 2010 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараахь саналтай байна.

Тайлангийн дүгнэлтийн төслийн:

ҮАГ-ын тайлбар
1-ийг үзнэ үү.

1. <<1.18 Иймээс зарим захиалагч он дамжин хэрэгжих БУА-д тухайн жилд батлагдсан төсөвт багтаан жил бүр тендер зарлаж, тус тусдаа гэрээ байгуулж байна>> гэснийг 1.18 Дээрхи 1.6 дахь заалт нь захиалагч он дамжин хэрэгжих БУА-д тухайн жилд батлагдсан төсөвт багтаан жил бүр тендер зарлаж, тус тусдаа гэрээ байгуулах нөхцөлийг бий болгож байна гэж өөрчлөх

ҮАГ-ын тайлбар
2-ыг үзнэ үү.

2. <<1.20 Түүнчлэн орон нутаг барилгын хүчин чадлыг нэмэгдүүлснээс хөрөнгө дутагдаж, хугацаа алдах явдал гарч байна. Тухайлбал, Архангай аймгийн Цэцэрлэг сумын 100 ортой цэцэрлэгийн БУА орон нутагт эрх шилжсэн бөгөөд анх 50 ортой 262,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийг "Аяа" ХХК 2008 оноос барьж эхэлсэн боловч даруй нь хүчин чадлыг 100 ортой болгон нэмэгдүүлснээс суурь томсч төсөвт өртөг 428,0 сая төгрөг болсон байна. Хуульд заасан гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа хоёрыг адилтган ойлгосноос гэрээний заалт хэрэгжихгүй байна>> гэснийг

1.20 Түүнчлэн орон нутгийн болон УИХ-ын гишүүний санаачилгаар барилгын хүчин чадлыг нэмэгдүүлснээс хөрөнгө дутагдаж, хугацаа алдах явдал гарч байна. Тухайлбал, Архангай аймгийн Цэцэрлэг сумын 100 ортой цэцэрлэгийн БУА орон нутагт эрх шилжсэн бөгөөд анх 50 ортой 262,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийг "Аяа" ХХК 2008 оноос барьж эхэлсэн боловч орон нутгийн болон УИХ-ын санаачилгаар хүчин чадлыг 100 ортой болгон нэмэгдүүлснээс суурь томсч төсөвт өртөг 428,0 сая төгрөг болсон дахин зургаа өөрчлөх, дутуу хөрөнгийг олох тэсвэр 3 жил үргэлжилж сүнсирсэн байна. Хуульд заасан гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа хоёрыг адилтган ойлгох явдал гарсан байна гэж өөрчлөх.

ҮАГ-ын тайлбар
3-ыг үзнэ үү.

3. <<1.25 Тус яам хэт бага үнийн саналаар тендерт ялж, явцын дунд үнийн зөрүү нэмэгдсэн, барилга байгууламжийг ашиглалтанд оруулахгүй саатуулдаг сөрөг явдлыг зогсоох зорилгоор тендерийн үнийн доод хязгаарыг төсөөс тооцон ТББ-г тусгах ажлыг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

My doc. /Alban.txt/14

906283

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын соёлын төвийн барилгад төсвийн тухай хуулиар 460,0 сая, үнэлгээний хорооны хуралд нарийн бичгийн даргын танилцуулснаар 505,0 сая, улсын экспертиз Н.Цэрэнбалтав магадлал хийсэн 689,1 сая төгрөг гэсэн гурван өөр төсөвт өртөг байна. Үнэлгээний хорооны гишүүдийн саналаар ТББ-т ирүүлсэн үнийн санал нь 90 хувиас бага тохиолдолд ирүүлсэн үнийн саналыг хэт бага гэж үзэн тендерээс татгалзана гэсэн заалт оруулсан нь дээрхи төсөвт өртгүүдийн чухам алины 90 хувь болох нь тодорхойгүй байна >>гэснийг

1.26 Тус яам хэт бага үнийн саналаар тендерт ялж, явцын дунд үнийн зөрүү нэхэмжлэн, барилга байгууламжийг ашиглалтанд оруулахгүй саатуулдаг сөрөг явдлыг зогсоох, чанаргүй барилгын болон засварын ажил гүйцэтгэх явдлыг гаргуулахгүй байх зорилгоор тендерийн үнийн доод хязгаарыг төсвөөс тооцон ТББ-т тусгах ажлыг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Гэвч зарим тохиолдолд ямар тооноос хэт бага үнийн саналыг яаж тооцохоо мэдэхгүй байх явдал гарсан байна. Тухайлбал:

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын соёлын төвийн барилгын тухайд төсвийн тухай хуулиар 460,0 сая, үнэлгээний хорооны хурлын даргын баримталснаар 505,0 сая, улсын экспертиз Н.Цэрэнбалтав магадлал хийсэн 689,1 сая төгрөг гэсэн гурван өөр төсөвт өртөг байна. Үнэлгээний хорооны гишүүдийн саналаар ТББ-т ирүүлсэн үнийн санал нь 90 хувиас бага тохиолдолд ирүүлсэн үнийн саналыг хэт бага гэж үзэн тендерээс татгалзана гэсэн заалт оруулсан нь дээрхи төсөвт өртгүүдийн чухам алины 90 хувь болох нь тодорхойгүй байна гэж өөрчлөх

4. <<1.27 Цаашид хэт бага үнийн санал ирүүлсэн этгээдийн тендерээс татгалзах нөхцлийг ТББ-т заахдаа төсвийн тухай хуулиар баталсан төсөвт өртөг ба экспертизээр баталсан төсөвт өртгийн алийг шалгуур үзүүлэлт болгохыг тодорхой болгон журамлах шаардлагатай байна >>гэснийг

1.27 Цаашид хэт бага үнийн санал ирүүлсэн этгээдийн тендерээс татгалзах нөхцлийг ТББ-т заахдаа экспертизээр тогтоогдсон төсөвт өртгөөс тооцно гэсэн заалтыг журамлаж өгөх хэрэгтэй байна гэж өөрчлөх.

5. <<1.30 Энэ нь баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан эвдрэл гэмтэл гарах тохиолдолд түүнд засвар хийх хөрөнгийн найдвартай эх үүсвэргүй болгож байна >> гэснийг

1.30 Энэ нь баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан эвдрэл гэмтэл гарах тохиолдолд түүнд засвар хийх хөрөнгийн найдвартай эх үүсвэргүй болгож байна. Мөн баталгаат засварын хугацаа 3 жил байхаар Барилгын хуульд заасан боловч баталгаат засварын барьцаа хөрөнгийг 1 жил байхаар жишиг тогтсон байна гэж өөрчлөх

6. 1.32-д заасныг бүхэлд нь хасах саналтай байна.

7. <<1.33 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6^б-д заасны дагуу үнийн дүнгийн 5 хувийг барьцаалах нөхцлийг гэрээнд тусгадаг боловч барьцаа хөрөнгийг байршуулаагүй байна>> гэснийг

1.33 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6^б-д заасны дагуу үнийн дүнгийн 5 хувийг барьцаалах нөхцлийг гэрээнд тусгадаг боловч барьцаа хөрөнгө болгон байршуулаагүй гүйцэтгэлийн баталгаа хэлбэртэйгээр 1 жил хадгалагддаг байна гэж өөрчлөх.

8. <<1.34 Баталгаат засварын барьцаа байршуулахгүй байгаагаас гарч болох үр дагаврыг анхаарч цаашид баталгаат засварын барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулж байхаар журамлах шаардлагатай байна >> гэснийг

1.34 Гүйцэтгэлийн баталгааг баталгаат засварын барьцаа болгон байршуулахгүй байгаагаас гарч болох үр дагаврыг анхаарч цаашид баталгаат засварын барьцаа

ҮАГ-ын тайлбар
4-ийг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
5-ыг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
6-г үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
7-г үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
8-ыг үзнэ үү.

хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулж байхаар журамлах шаардлагатай байна гэж өөрчлөх

ҮАГ-ын
тайлбар
9-ийг
үзнэ үү.

9. 1.41 дэх хэсгийн Монгени сургуулийн өргөтгөл, спорт заалны барилга, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, спорт заалны барилгатай холбоотой хэсгийг дор дурдагдснаар өөрчлөх.

1 дэх хэсэгт

Монгени сургуулийн өргөтгөл, спорт заалны барилгыг 2009 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ашиглалтанд оруулах 575,6 сая төгрөгийн гэрээг "МБҮ" ХХК-тай 2008 онд байгуулсан боловч графикийн дагуу ажлаа гүйцэтгээгүй тул ТНБД-ын тушаалаар гэрээ цуцлах хариуцлага ногдуулсан байна. Дахин тендер зарлаж, "Зос трейд" ХХК-тай 2010.10.03-ны өдөр гэрээ байгуулан БУА-ыг 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүлээлгэн өгөх 350,0 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна. Энэ нь тухайн онд батлагдсан хөрөнгөөр тухайн онд нь багтаан ажил гүйцэтгэх тухай төсвийн хуулинд захируулсан мэт харагдавч бодит амьдрал дээр өвлийн улиралд /11,12 сард/ барилгын угсралтын ажил явагдах бололцоогүй байна гэж.

2 дахь хэсэгт

Уг барилгын төсөвт өртөг 629,0 сая төгрөг бөгөөд анхны гүйцэтгэгч "МБҮ" ХХК-д 293,7 сая, шинээр шалгарсан "Зос трейд" ХХК-д 313,0 сая, нийт 606,7 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь төсөвт өртгийн 96,5 хувийг эзэлж байгаа боловч 2010 оны эцсийн байдлаар БУА 56,0 хувийн гүйцэтгэлтэй, хавар ажлаа үргэлжлүүлж дуусгах яриатай байв гэж.

6 дахь хэсэгт

Спорт заалны суурь тавьсан боловч баганын тэнхлэг зөрсөн, хийсэн ажил нь авсан санхүүжилтээсээ 115,2 сая төгрөгөөр дутуу болохыг улсын экспертизээр тогтоосон ба Дэлгэр интернейшил компаниар суурийн алдааг засуулж хүлээж авч үлдэгдэл зөрүүг нэхэмжилж аваагүй байгаа тул шаардлага хүргүүлэв гэж.

11 дахь хэсэгт

Дахин зарласан тендер "Ганменхжин" ХХК шалгарч, 2010 онд Дэлхийн зөн ОУБ-ын Монголын талын хөрөнгөд батлагдсан 100 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө 130 сая төгрөг нийт 230 сая төгрөгөөр гэрээ хийсэн байна гэж.

10. <<1.42 Өмнөх жилүүдэд барилга объектийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг бүрэн шийдээгүй байхад хөрөнгө батлан барилгын ажлыг эхлүүлснээс хугацаандаа ашиглалтанд орохгүй он дамжин сунжрах явдал гарч байна >>гэснийг

1.42 Өмнөх жилүүдэд барилгын газар техникийн нөхцөл болон төлөвлөлттэй холбоотой асуудлыг бүрэн шийдээгүй байхад хөрөнгө батлан барилгын ажлыг эхлүүлснээс хугацаандаа ашиглалтанд орохгүй он дамжин сунжрах явдал гарч байна гэж өөрчлөх

- Бохир усны техникийн нөхцөлд заасан цэг нь хувь хүний эзэмшлийн шугам, худаг байснаас УСУГ-т асуудлыг дахин тавьж уг хүнтэй тохирсны дагуу БСШУЯ эдгээр ажлыг гүйцээж 2011 оны 5 дугаар сарын 1-ний дотор хүлээлгэн өгөх 103,2 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулсан гэснийг
- Бохир усны техникийн нөхцөлд заасан цэг нь хувь хүний эзэмшлийн шугам, худаг байснаас УСУГ-т асуудлыг дахин тавьж уг хүнтэй тохирсны дагуу БСШУЯ эдгээр ажлыг гүйцээж 2011 оны 5 дугаар сарын 1-ний дотор хүлээлгэн өгөхөөр 103,2 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулсан гэж өөрчлөх

11. 1.45-ийн

- Одоогоор БУА-ын гүйцэтгэл 44,0 хувьтай, 2010 онд 255,0 сая, 2011 онд 1000,0 сая төгрөг батлагдсан боловч нийт санхүүжилтийн хэмжээ тодорхой бусаас гэрээг шалгачлан хийгээгүй гэснийг

ҮАГ-ын
тайлбар
10-ыг
үзнэ үү.

ҮАГ-ын
тайлбар
11-ийг
үзнэ үү.

- Одоогоор БУА-ын гүйцэтгэл 44,0 хувьтай, 2010 онд 255,0 сая, 2011 онд 1000,0 сая төгрөг батлагдсан боловч нийт санхүүжилтийн хэмжээ бүрэн батлагдаагүйгээс гэрээг шинэчлэн хийгээгүй гэж өөрчлөх.

Аудитын тайлангийн дүгнэлтийн төсөлд оруулах өөрчлөлтийн саналыг судлан үзэж тусгаж өгөхийг хүсье.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРХЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД САНХҮҮ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  С.НАРАНЦОГТ





МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Слэвгийн гудамж 2, Засгийн газрын VIII Байр
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.mn, http://www.moh.mn

2011.05.23 № 15/1667

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танайхаас ирүүлсэн "Эрүүл мэндийн салбарт
2010 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүн"-д
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх зарчмын өөр
саналгүй болно

ДЭД САЙД  Ж.ЦОЛМОН

082265

- Тайлбар 1. Тайлангийн 1.18 дахь заалт нь 1.16, 1.17 дахь заалтуудтай уялдан тодорхой тайлбарлагдсан байх тул засвар хийх шаардлагагүй гэж үзлээ.
- Тайлбар 2. Саналыг хүлээн авч “дахин зураг хийлгэх, дутуу хөрөнгийг батлуулахад цаг алдаж 3 жил сунжирсан байна” гэсэн тодотгол орууллаа.
- Тайлбар3. Тайлангийн 1.26, 1.27 дахь заалтууд уялдан тайлбарлагдсан байх тул өөрчлөлт оруулах шаардлагагүй.
- Тайлбар 4. Өөрчлөлт оруулах боломжгүй.
- Тайлбар 5. Нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй.
- Тайлбар 6. 1.32 дахь заалтыг хасах боломжгүй.
- Тайлбар 7. Зохих нэмэлт өөрчлөлтийг оруулав.
- Тайлбар 8. Гүйцэтгэлийн баталгааг нэг жилээр сунгаж хадгалдаг байна гэж нэмэлт оруулав.
- Тайлбар 9. Тайлангийн 1.41 дэх заалтын 1 дэх хэсэгт засвар хийх шаардлагагүй.
2 дахь хэсэгт засвар хийх шаардлагагүй.
6 дахь хэсэгт засвар хийх шаардлагагүй.
11 дэх хэсэгт “улсын төсвийн 130.0 сая төгрөг, нийт 230.0 сая төгрөгийн гэрээ хийсэн байна” гэж тодотгов.
- Тайлбар 10. “барилга объектын төлөвлөлттэй холбоотой асуудал”-д барилгын газар, техникийн нөхцөл хамаарах тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.
- Тайлбар 11. “нийт санхүүжилтийн хэмжээ тодорхой бусаас” гэснийг “нийт санхүүжилтийн хэмжээ бүрэн батлагдаагүйгээс” гэж өөрчлөв.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Нэг. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт:

1. Сангийн яамны худалдан авах ажиллагааны цахим хуудаст тендерийн урилгыг бүрэн байршуулж хэвшүүлэх;
2. Тендерийн үнийн доод хэмжээг ТББ-т заахдаа ямар төсөвт өртгийг шалгуур болгох асуудлыг судалж шийдвэрлэх;
3. ТБОНӨХБАҮХАТХ-д”... захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасны дагуу орон нутагт эрх шилжүүлсэн барилга объектын БУА-ын явцад тавих хяналтыг сайжруулах;
4. Захиалагчийн зүгээс гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай тооцох хариуцлагыг чангатгаж, гүйцэтгэгч сольсон тохиолдолд хийсэн ажил, олгосон санхүүжилтийн зөрүүг холбогдох журмын дагуу тодорхойлж, буруутай этгээдээс нэхэмжилж авах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагаар шийдүүлж байх.

Хоёр. Эрүүл мэндийн сайд С.Ламбаад:

1. Худалдан авах ажиллагаанд баримтлах журмыг зөв сонгох, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жилийн эхэнд төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж байх;
2. Орон нутагт эрх шилжиж буй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, тогтмолжуулах, бодит бус гүйцэтгэлээр оны эцэст санхүүжилт олгох явдлыг зогсоох;
3. Улсын экспертизийн дүгнэлтээр зураг, төсвийг баталгаажуулсны дараа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, дууссан барилга объектуудын улсын комиссын дүгнэлт гаргуулах ажлыг шуурхай зохион байгуулж байх;
4. Гүйцэтгэгчтэй хийх гэрээний хариуцлагыг сайжруулах, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцож байх.

БШУ-ны салбарт улсын төсвөөс 2010 онд санхүүжүүлсэн барилга объектын судалгаа

№	Барилга объектын нэр	Хэрэглэх хугацаа	Төсөвт өртөг /сая төг/	2010 онд батлагдсан төсөв /сая төг/	Гүйцэтгэлийн нэр	Гэрээний дүн /сая төг/	Ажлын нөц	Тайлбар
1	Сургуулийн барилга, 320 суудал /Ховд, Жаргалант/	2008-2010	1 200,00	640,00	"Ховдтулга" ХХК	1178,9	74,40	Сургуулийн барилгын өрөг хийгдэж дууссан дотор гадна шавардлага хийгдэж байна. Спорт заалны багана цутгалт хийгдсэн. Тогооны барилга барьж байна. Газрын асуудал удааширсан, цэвэр, бохир усны дэд өргөөний байрлал өөрчлөгдсөн, спорт заал нэмж барих болсон зэргээс шалтгаалсан.
2	Сургуулийн барилга, 640 суудал /УБ, БГД, 1-4-р хороо/	2008-2011	1 900,00	800,00	"Цаст констракшн" ХХК	1849,9	49,60	Аж 928 суудалтай төлөвлөгдсөн боловч газрын маргаанаас 2 жил саатаж, дахин олгосон газарт тааруулан 640 суудалтай болгож, 2010 оны 4 дүгээр сард гэрээ хийсэн.
3	Сургуулийн барилга, 520 суудал /Ховд, Мөст/	2008-2011	1 407,30	707,30	"Нью прогресс" ХХК	1407,3	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
4	Сургуулийн барилга, 928 суудал /Хөвсгөл, Мөрөн/	2008-2011	2 400,00	1 100,00	"Хөвсгөл геолог" ХХК	2399,0	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
5	Сургуулийн барилга, 640 суудал /Дорнод, Хэрлэн/	2008-2011	1 483,20	823,20	"Авазага трейд" ХХК	1377,5	44,00	Яам төндөр зарлаж гүйцэтгэгч шалгарсан. Барилгын 2-р давхарын багана, дам нурууны цутгалт хийгдэж байна.
6	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, спорт заал, 15*30м /Булган, Дашинчилэн/	2008-2011	1 670,00	800,00	"Машин механизм" ХХК	1666,7	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
7	Сургуулийн барилга 320 суудал /Завхан, Их-Уул/	2008-2010	800,00	550,00	"Морин суд" ХХК	689,5	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
8	Сургуулийн барилга, 640 суудал /Завхан, Тосонцэнгэл/	2008-2011	2 090,00	900,00	"Самосон" ХХК	1379,7	38,40	Б.В.Г Блокны 1-р давхарын хучилт цутгаж байна. А блокын суурь цутгаж байна.
9	Сургуулийн өргөтгөл 5 анги, номын сантай /Хэнтий, Бор-Өндөр/	2008-2010	760,50	370,50	"ЭВМТХ" ХХК	580,5	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
10	Сургуулийн барилга, 920 суудал /Дорноговь, Сайншанд/	2008-2011	1 997,00	400,00	"Дархан трейд" ХХК	1997,0	56,00	2009 онд суурь болон спорт урлагын заалны өрөг хийгдсэн. А, Б блокын өрөг хийгдэж байна.

													Б блокны 1,2-р давхарын өрөг хийгдсэн 2-р давхарын хамар ханын өрөг хийгдэж байна.В блокны суурийн хучилт хийгдсэн. Тогооны Барилгын ажил дууссан.Төсөвтөө багтахгүй болсноос А блокыг (захираг, менежерийн өрөө, цайны газар) хассан.
11	Сургуулийн барилга, 320 суудал /Завхан, Түдэвтэй/	2009-2011	1 400,00	680,00	"Нийслэл өргөө" ХХК	860,0	56,00						
12	Сургуулийн барилга, 640 суудал /Хантуй, Биндэр/	2009-2011	1 530,00	700,00	"Бүтээгч шинэ сонголт" ХХК	1380,0	62,40						Барилгын 3-р давхарын өрөг хийгдэж байна.
13	Сургуулийн барилга, 640 суудал /УБ, СХД/	2008-2011	1 530,00	800,00	"Интеко инженеринг" ХХК	1529,0	32,80						2008 онд төсөв батлагдсан боловч газрын асуудлаас шалтгаалж тодотголоор хасагдаад, 2010 онд холболтын зургаар гараж хийж эхэлсэн. Барилгын суурийн ажил хийгдэж байна.
14	Сургуулийн өргөтгөл, 320 суудал /Завхан, Хөгжмийн сургалттай сургууль/	2008-2011	1 400,00	400,00	"ЛСБ" ХХК	1398,9	44,00						Барилгын 2-р давхарын бөгийн карказ цутгасан.
15	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Галт/	2008-2011	725,70	725,70	"Хөвсгөл геолог" ХХК	725,7	100,00						Улсын комисст хүлээлгэн өгсөн
16	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Жаргалант/	2009-2010	700,00	700,00	"Идэр чандмань" ХХК	750,0	100,00						Улсын комисст хүлээлгэн өгсөн
17	Сургуулийн барилга, 640 суудал /Өвөрхангай, Уянга/	2009-2011	2 090,00	700,00	"Химон констракшн" ХХК	1632,1	44,00						Барилгын 2-р карказ цутгалт хийгдэж хүчилт тавьсан. 500сая төгрөгөөр суурийн тэндер зарлаж 2010 онд дуусгаж, яамнаас гэрээ сунгасан.2009 оны 500 сая төгрөгөө авч чадаагүй, 2010 онд 700.0 сая төгрөг олгосон.
18	"Хангай" цогцолбор сургуулийн хөдөөгийн байрны өргөтгөл, 320 суудал /УБ, Багахангай/	2009-2011	880,00	150,00	"Хөв хайрхан трейд" ХХК	478,5	66,40						Барилгын ханын өрөг хийгдэж дууссан хучилт хийж байна.
19	Сургуулийн барилга, спорт заал /Сэлэнгэ, Сүхбаатар /	2010-2012	2 400,00	400,00	"КТК" ХХК	2162,3	32,80						Барилгын суурийн ажил хийгдэж байна.
20	Сургуулийн барилга, спорт заал /Булган, Гурванбулаг/	2010-2011	1 600,00	300,00	"Аваага трейд" ХХК	1361,6	32,80						Барилгын суурийн ажил хийгдэж байна.
21	Сургуулийн барилга, /Дундговь, Өндөршил/	2010-2011	1 000,00	300,00	"ААББ" ХХК	815,0	32,80						Барилгын газар шорооны ажил дууссан суурийн цутгалт хийгдсэн.
22	Сургуулийн барилга, /Говьсүмбэр, Сүмбэр/	2010-2011	1 600,00	370,00	"Назу" ХХК	1522,1	38,40						Барилгын А,Б,В блокны ул бетон цутгасан, Г,Д блокны суурийн ажил хийгдэж Г блокны 2-р давхарын өрөг хийгдэж байна.
23	Сургуулийн өргөтгөл, 8 анги /Ховд, Манхан/	2010-2011	750,00	510,00	"Алтайн Буулмаст" ХХК	488,7	100,00						Улсын комисст хүлээлгэн өгсөн
24	Сургуулийн барилга, 320 суудал /Завхан,Отгон/	2010-2011	950,00	500,00	"Арт-Утгаал" ХХК	500,0	32,80						Талбайд суурийн блок цутгаж суурийн угсралт хийгдэж байгаа. Материал татсан.Мөнх цэцэгтэй тул 11 сарын 20-ноос хойш ажил эхлэхгүй автор зөвшөөрсөн.

25	Сургуулийн барилга, 320 суудал спорт заал шинэчлэл 12-24 /Баянхонгор, Галуут /	2008-2010	726.60	99.20	"Материал трейд" ХХК	711,1	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
26	Сургуулийн барилгын өргөтгөл 3 анги, спорт заал /Төв, Батсүмбэр/	2008-2010	385.00	4.20	"Төмөр хүлэг" ХХК	314,5	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
27	Сургуулийн өргөтгөл, 320суудал, спорт заалны барилга, "Монгени" сургууль /Улаанбаатар/	2008-2010	629.00	335.30	"Зос трейд" ХХК	575.6	56,00	"МБУ" ХХК барилга усралтын ажлыг гүйцэтгэж байсан боловч ажлыг гэрээт хугацаандаа чанартай хийж гүйцэтгээгүй тул гэрээ цуцлаж шинээр гүйцэтгэгч шалгаруулсан.
28	Сургуулийн барилга, 640 суудал /Говь-Алтай, Баян-Уул/	2010-2010	300,00	300,00	"Ургашлах" ХХК	1600,0	15,00	2010 онд Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтад 300.0 сая төгрөг батлагдсан боловч зарцуулаагүй. Зураг төсвийг аймаг хийлгэж 1600.0 сая төгрөг гарсан тул 2011 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг нэмэгдэж, хэрэгжих хугацааг 2010-2012 он болгож , 1300.0 сая төгрөг батлагдсан. Орон нутагт ХАА ахэлсэн боловч төсөвт өртөг нь орон нутгийн ЗД-ын эрхээс давсан тул яаманд шилжсэн Яам төндөр зарлаж 2011 оны 1 сард гүйцэтгэгч шалгарсан.
29	Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Говь-Алтай, Төгрөг/	2010-2010	50,00	50,00	"Шалаг" ХХК	50,0	32,80	2010 онд Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтад 50.0 сая төгрөг батлагдаж, орон нутагт гүйцэтгэгч шалгарсан. Энэ хөрөнгөөр барилгын суур, хийгдэж ажил зогссон. Зураг төсвийг аймаг хийлгэж, төсөвт өртөг 378.9 сая төгрөг гарснаас зөрүү 328.6 сая төгрөгийг 2011 онд баталсан.
30	Сургуулийн барилга, 640 суудал /Төв, Баянхонгор/	2010-2011	500,00	500,00	"Тусгал төв" ХХК	500,0	56,00	500.0 сая төгрөг батлагдаж, орон нутагт гүйцэтгэгч шалгарсан. Төсөвт өртөг 1679.9 сая төгрөг гарснаас яаманд шилжсэн А блокоос бусад блокууд суурийн ажил хийгдсэн. Б блокны дээврийн ажил хийгдэж байна. Г блокны 1-р давхарын өрөг хийгдэж байна, гадна усан хангамжийн ажил хийгдсэн.
31	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Баян-Өнжүүл/	2010-2011	300,00	300,00	"Хангицац" ХХК	295,0	74,40	300.0 сая төгрөг батлагдаж, орон нутагт гүйцэтгэгч шалгарсан. Төсөвт өртөг 1280.3 сая төгрөг гарснаас яаманд шилжсэн. 2010 онд батлагдсан хөрөнгөнд багтааж 1 блок барьж, засал хийгдэж байна.
32	Сургуулийн хичээлийн байрны өргөтгөл /Увс, Улаангом/	2010-2010	230,00	230,00	"Тобин тревел" ХХК	223,0	62,40	Орон нутагт эрх шилжих гүйцэтгэгч шалгарсан. Тус хөрөнгөөр Эрдэм оргил, Шинэ ирээдүй цогцолборт өргөтгөл барьж байна. 1-р давхарын өрөг хийж дууссан.

33	Сургуулийн барилга, 960 суудал /Ховд, Жаргалант, Прогресс/	2010-2010	110,00	110,00	110,00	Геологийн ХХК	2310,0	22,40	2010 онд Бус, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтад 110.0 сая төгрөг батлагдсан. Зураг төсвийг аймаг хийлгэж, төсөвт өртөг 2.2 тэрбум төгрөг гарсан, 2011 онд 1.2 тэрбум төгрөг батлагдсан.
34	Сургуулийн өргөтгөл /Ховд, Дарви/	2010-2010	300,00	300,00	300,00	"Бя Цо" ХХК	288,4	66,40	Орон нутагт эрх шилжих гүйцэтгэгч шалгарч ажил эхэлсэн. Барилгын 2-р даваарын өрөг хийгдэж хуучилт хийж байна.
35	Сургуулийн барилга /Хэнтий, Дэлгэрхаан/	2010-2011	500,00	500,00	500,00	"Оч манлай"	495,0	98,40	Техникийн комисс ажилласан.
36	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Увс, Тэс/	2008-2010	532,30	532,30	532,30	"Арчажих үеэс"	527,1	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
37	Дотуур байрны өргөтгөл /Хэнтий, Бор-Өндөр/	2008-2010	541,00	541,00	201,00	"Мон инок трейд" ХХК	541,9	96,00	Орон нутагт гүйцэтгэгч шалгарсан. 2010 онд хөрөнгө нэмж шаардагдан 61 сая төгрөг нэмж олгоосон. Барилга угсралтын ажил дууссан засал хийгдэж байна.
38	Дотуур байр /Говь-Алтай, Цогт/	2007-2010	338,60	338,60	188,60		338,6	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
39	Спорт заал, дотуур байрны барилга, 240 ор. /Өмнөговь, Даланзадгад/	2008-2010	1 351,50	1 351,50	851,50	"НЭМҮТ" ХХК	1251,5	98,40	Техникийн комисс ажилласан.Зарим ажлыг дулааны улиралд хийнэ.
40	Дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Баяндалай/	2009-2011	621,40	621,40	150,00	"Наран өрөг констракшн"	565,9	62,40	Барилгын 2-р даваарын хэвн тоосгон өрөг дууссан.
41	Сургуулийн дотуур байр, 150 ор. /Архангай, Хотонт/	2009-2011	750,00	750,00	100,00	"РСТ" ХХК	550,0	49,60	Барилгын карказ, хуучилтын цутгалт хийгдсэн. Дотуур байр ашиглалтад орсноор сумын уурын зууны хүчин чадал дутагдаж, түүнд өртөгтөл хийж байна.
42	Дотуур байрны барилга, 150 ор /Увс, Өмнөговь/	2010-2011	750,00	750,00	550,00	"Дурт Уул" ХХК	735,0	49,60	Барилгын 2-р даваарын хуучилт, дээвэр хийгдэж байна.
43	Дотуур байрны барилга, 150 ор /Завхан, Дөрвөлжин/	2010-2011	550,00	550,00	300,00	"РСТ" ХХК	550,0	44,00	Барилгын 2-р даваарын карказ цутгалт хийгдсэн.
44	Сургуулийн дотуур байрны өргөтгөл /Дундговь, Өлзийт/	2010-2010	100,00	100,00	100,00	"ВЕТ" ХХК	100,0	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
45	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, 100 ор. /Булган, Булган сум/	2008-2011	494,60	494,60	49,50	"Төмөр хулга" ХХК	494,6	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
46	Мэргэжлийн сургалттай сургуулийн дотуур байрны барилга, 120 ор. /Говь-Эрдэнэ/	2008-2010	572,70	572,70	20,00	"Тэд констракшн" ХХК	550,0	100,00	Ашиглагч байгууллагын шаардлагаар (тодотголоор 20.0 сая төгрөг нэмж батлуулсан) гүнийн худал нэмж гарган, улсын комисст хүлээлгэн өгсөн.

										2010 онд Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтад 250.0 сая төгрөг батлагдсан ба орон нутагт төндөр зарлаж гүйцэтгэгч шалгарсан. Зураг төсвийг аймаг хийлгэсэн төсөвт өртөг 556.6 сая төгрөг гэрсэн. Барилгын газар шорооны ажил хийгдэж дуусч суурийн ажил хийгдсэн байна.
47	Дотуур байрны барилга /Архангай, Хашаат/	2010-2010	250,00	250,00	250,00	"Өлзийчилэг" ХХК	449,9	32,80	100,00	Засвар хийж хүлээлгэн өгсөн.
48	Дотуур байрны барилга /Говь-Алтай, Баянцогт/	2010-2010	140,00	140,00	140,00	"Буянт гол" ХХК	154,0	100,00	100,00	Засвар хийж хүлээлгэн өгсөн.
49	Дотуур байрны барилга /Ховд, Буянт/	2010-2010	400,00	400,00	400,00	"Аага ач нар" ХХК	399,8	98,40	98,40	Барилгын угсралтын ажил дууссан. Техникийн комисс ажилласан.
50	Спорт заалны барилга /Дорнод, Булган/	2008-2010	232,30	232,30	202,70	"Аригун" ХХК	232,3	100,00	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
51	Тосоны 4 дүгээр сургуулийн спорт заалны барилга /Дархан-Уул/	2008-2010	350,00	350,00	90,00	"Жавнар" ХХК	254,0	100,00	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
52	Спорт заалны барилга, 12*18 /Дорноговь, Сайншанд, 3-р сургууль/	2007-2010	251,60	251,60	60,60	"Анар сан" ХХК	190,6	100,00	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
53	Спорт заалны барилга 12x24м /Ховд, Мөнххайрхан/	2009-2011	300,00	300,00	300,00	"Турлимаг" ХХК	300,0	88,00	88,00	Барилгын хэцүү өрөг хийгдэж дээвэр тавьсан. Гадна дотор засал хийсэн. Техникийн комисс ажилласан.
54	Спорт заалны барилга, /Хэнтий, Өмнөдэлтэр/	2006-2010	860,40	860,40	139,00	"Суварга эв" ХХК	139,0	44,00	44,00	Дэлгэр интернайшил ХХК сургуулийн барилгыг улсын комисст өгсөн. Спорт заалны суурь тавиад гэрээ цуцлагдсан. Орон нутагт эрх шилжсэн. Сургуулийн спорт заалны барилгын суурийн ажил хийгдэж төмөр карказ угсарч байна. Барилгын материал татан авсан байна.
55	Спорт заалны барилга 12x18 /Хөвсгөл, Рашаант/	2009-2011	382,90	382,90	150,00	"Сант өндөр" ХХК	398,0	62,40	62,40	Суурийн ажил дууссан багана угсралт дуусаж хэцүү өрөг хийгдэж байна.
56	Спорт заалны барилга /Архангай, Батцэнгэл/	2010-2010	250,00	250,00	250,00	"Алтанбулаг трейд" ХХК	285,9	32,80	32,80	2010 онд Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтад 250.0 сая төгрөг батлагдсан ба орон нутагт төндөр зарлаж гүйцэтгэгч шалгарсан. Зураг төсвийг аймаг хийлгэсэн, уг барилгын төсөвт өртөг 309.7 сая төгрөг. Барилгын суурийн ажил дууссан. Барилгын хэцүү өрөг хийгдэж байна. 2011 онд 20.0 сая төгрөг батлагдсан.
57	Спорт заалны барилга /Архангай, Цэнхэр/	2010-2010	250,00	250,00	250,00	"Тураан тамир" ХХК	249,6	38,40	38,40	2010 онд Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтад 250.0 сая төгрөг батлагдсан ба орон нутагт төндөр зарлаж гүйцэтгэгч шалгарсан. Зураг төсвийг аймаг хийлгэсэн, уг барилгын төсөвт өртөг 302.0 сая төгрөг тул зөрүү 52.0 сая төгрөг 2011 оны төсөвт батлагдсан. Барилгын суурь болон карказын ажил хийгдэж байна.

58	Цэцэрлэгийн барилга, 60 ор /Архангай, Батцэнгэл/	2007-2010	185,00	45,00	"Би Ди Эйч Эс" ХХК	184,8	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
59	Цэцэрлэгийн барилга, 60 ор /Өмнөговь, Ноён/	2008-2010	395,90	266,00	"Комп трейд" ХХК	353,6	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
60	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Өмнөговь, Хурмэн/	2008-2010	396,20	146,20	"Комп трейд" ХХК	347,6	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
61	Цэцэрлэгийн барилга, 140 ор /Дорнод, Цагаан-Овоо/	2008-2010	612,00	61,40	"Синчи Ойл" ХХК	611,4	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн.
62	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ув, Багануур, 4-р хороо/	2008-2010	306,00	200,00	"Комп трейд" ХХК	0,0	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
63	Цэцэрлэгийн барилгын дуусгал, уурын зуух, 80 ор /Ув, БЗД, 23-р хороо, 6-р цэцэрлэг/	2008-2011	360,00	235,00	"Фамли кон" ХХК	549,4	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
64	Цэцэрлэгийн барилгын дуусгал, 50 ор /Ув, БЗД, 16-р хороо, 21-р цэцэрлэг/	2008-2011	150,00	86,00	"Конкомм" ХХК	222,6	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
65	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх	2008-2010	499,00	180,00	"СБМ" ХХК	0,0	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
66	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн 150 ор /Улаанбаатар/	2009-2010	990,00	720,00	"Хангайрхан" ХХК	940,0	92,00	Сууринд цууралт үүсч, суурийн бэхлэлийн зураг хийлгэснээс цаг алдсан. БУА хийгдсэн, дулаан авч чадаагүйгээс дотоод засал зогссон, дээрхийн ажил дулаалга хийгдэнэ.
67	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Баянхонгор, Баянхонгор, 7-р баг/	2009-2010	400,00	400,00	"Хөх Бүрдний эх" ХХК	375,6	96,00	Орон нутагт эрх шилжсэн. Барилгын угсралтын ажил дууссан, засал хийгдэж байна.
68	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай, Чигэстэй баг/	2008-2010	559,70	559,70	"ЛСБ" ХХК	559,7	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
69	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Өвөрхангай, Бат-Өлзий/	2008-2010	360,00	350,00	"Тэд констракшн" ХХК	318,8	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
70	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хэнтий, Дадал/	2010-2011	300,00	300,00	"Хар чоно" ХХК	300,0	32,80	Барилгын суурийн цутгал хийгдэж дууссан
71	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Хэнтий, Өлзийт/	2009-2011	208,10	208,10	"Оч манлай" ХХК	396,0	32,80	Гүйцэтгэгч шалгарсан, Суурийн ажил бүрэн хийгдэж дууссан.
72	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Сүхбаатар/	2009-2010	400,00	350,00	"Нэбсэн" ХХК	350,0	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн

73	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Сүхбаатар, 17-р хороо бэлгэ/	2009-2010	505,00	505,00	"ӨВМТХ" ХХК	445,5	85,00	Цахилгааны технологийн нөхцөл нь 16 дугаар хороо гэж гарснаас залруулахад цаг алдсан.Барилгын 2 давхарын өрөг хийгдэж хүчилт тависан. Цахилгаан, сан бохирын холболт хийгдсэн байна.
74	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4/7-р хороо/	2009-2010	505,00	505,00	"Хүжийн гал" ХХК	250,0	19,00	Газрын захирал ажлаа гэрээгээр удааширсан, Канад технологийн 4, 11-р хороонд цэцэрлэг барилга барих болж 11-р хорооны цэцэрлэгийг Хүжийн гал ХХК, 4-р хорооны цэцэрлэгийн барилгыг "Баз Констракшн" ХХК гүйцэтгэхээр 2010 оны 12 дугаар сард гэрээ байгуулж, бараа материал татан авсан.
75	Цэцэрлэгийн барилга 100 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 16-р хороо/	2008-2010	505,00	505,00	"Нэвү" ХХК	453,0	85,00	Газрын захирал нь 247 тоот хувийн хашааны дунд гарсан, тэр нь уугуул хахуу налуу дээр цэцэрлэг барих боломжгүй, өндөр хүчдэлийн дор байснаас цахилгааны технологийн нөхцөл өгөөгүй, дахин газрын захирал ажлаа гэрээ хэрэгжсэн. Гүйцэтгэгч 2-р давхарын өрөг, хүчилт хийгдсэн. Засах хийгдэж байна.
76	Цэцэрлэгийн өргөтгөл, 100 ор. /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 12-р хороо/	2008-2010	505,00	505,00	"Ордос" ХХК	457,4	100,00	Улсын комисст хүлээлгэн өгсөн
